

ОРЧИН 21

МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБОО

НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ БҮЮУ БИДНИЙ АМИН ЧУХАЛ ХЭРЭГЦЭЭ



4-34 ЦАГ ҮЙЛ ЯВДАЛ

Дээд газраас гаргасан тогтоолууд



35-54 МЭДЭЭЛЭЛ

МНААҮХолбооноос 2013 оны III улиралд зохион байгуулсан сургалт семинар



55-62 ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ

Өндөр түвшний цэвэрлэгээний нууц нь микробиологийн жижиг Биофилм юм



63-72 ЯРИЛЦЛАГА

П.Баатартуул: Хорооллын доторхи гадна инженерийн шугам сүлжээг хонгилын системд оруулсанаар урьдын бэрхшээл арилна.



73-79 ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА

ХХОСНАА-н “Хүрээ хаус” ХХК 5 нас хүрлээ



80-85 ХУУЛИЙН ЗӨВӨЛГӨӨ

Хог хаягдлын тухай



86-88 ЭРҮҮЛ МЭНД

Усны тусламжтай турах шинэ хөтөлбөр

ОРЧИН 21

ЭРХЛЭГЧ:

Б.Пүрэвжав

/Монгол улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан, Техникийн ухааны магистр, МУ-ын зөвлөх инженер/

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

Д.Басандорж /МУШУТИС/

С.Дагвадорж

/Таван Өндөр ХХК-ийн захирал/

ДИЗАЙНЕР:

С.Отгонсүх

СЭТГҮҮЛЧ:

Б.Баяртогтох

МЕНЕЖЕР:

Б.Алтантуул





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 3 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 128

Улаанбаатар хот

ИПОТЕКИЙН ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоол, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх замаар иргэдийг орон сууцжуулах зорилгоор Монголын ипотекийн корпорацид төр тодорхой хувь эзэмшихийг зүйтэй гэж үзэн, холбогдох байгууллагуудтай энэ чиглэлээр хэлэлцээ хийж, хэрэгжүүлэхийг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт даалгасугай.
2. Монголын ипотекийн корпорацид төр хувь эзэмших зорилгоор Хөгжлийн банкны эх үүсвэрээс 10.0 (арван) тэрбум хүртэл төгрөг зарцуулахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт зөвшөөрсүгэй.
3. Ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлснээр орон сууцны барилгажилтыг дэмжих хөтөлбөрийн төсөл боловсруулж Засгийн газарт оруулахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.АЛТАНХУЯГ

Эдийн засгийн хөгжлийн сайд Н.БАТБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 4 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

ИРГЭДИЙГ ОРОН СУУЦЖУУЛАХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоол, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Шинээр баригдаж бүрэн ашиглалтад орсон, 80 м²-аас дээшгүй талбай бүхий орон сууц эсхүл ашиглагдаж байгаа хуучин орон сууц худалдан авах хүсэлт гаргасан, тухайн орон сууцны үнийн дүнгийн 10-30 хувиас доошгүй урьдчилгаа төлбөр төлсөн иргэнийг жилийн 8 (± 1) хувийн хүүтэй, 20 хүртэлх жилийн хугацаатай, орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах журмыг Засгийн газраар батлуулж, арилжааны банкаар дамжуулан ипотекийн зээл иргэдэд олгох ажлыг зохион байгуулахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайханд даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргалд зөвлөсүгэй.

2. Орон сууцны нийлүүлэлтийг дэмжих зорилгоор ашиглалтад оруулахаар төлөвлөсөн, нэмэлт санхүүжилт шаардлагатай байгаа орон сууцны барилгын судалгааг үндэслэн үе шаттайгаар санхүүжүүлэх ажлыг арилжааны банкаар дамжуулан зохион байгуулахыг Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргалд зөвлөсүгэй.

3. Ипотекийн зээлээр орон сууц худалдан авах боломжгүй иргэдэд зориулсан “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг боловсруулан батлуулж, эхний ээлжинд 1300 айлын түрээсийн орон сууцыг 2013 онд барих ажлыг зохион байгуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр нарт даалгасугай.

4. Ипотекийн зээлийн эх үүсвэрийг шийдвэрлэх талаар санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан нарт даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргалд зөвлөсүгэй.

5. Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгон ипотекийн хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, Нийгмийн даатгалын санг мөнгөжүүлэх асуудлыг шийдвэрлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан нарт даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 138 дугаар тогтоол, “100 мянган айлын орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай” Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 341 дүгээр тогтоол, “100 мянган айлын орон сууц” хөтөлбөрт хамрагдах орон сууцны жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 82 дугаар тогтоол, “100 мянган айлын орон сууц” хөтөлбөрт хамрагдах орон сууцны жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2012 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 206 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд
Н.АЛТАНХУЯГ**

**Барилга, хот байгуулалтын сайд
Ц.БАЯРСАЙХАН**

**Эдийн засгийн хөгжлийн сайд
Н.БАТБАЯР**



МОНГОЛЫН ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙН САЛБАРЫН ТӨЛӨӨЛӨЛ ХУРАЛДАЖ УРИАЛГА ГАРГАЛАА

Монголын Нийтийн Аж Ахуйн Үйлчилгээний холбооны “Бүх гишүүдийн ээлжит III хурал” энэ оны 05 дугаар сарын 17-нд Улаанбаатар хотноо боллоо.

Ээлжит хуралдаанд аймаг нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 60 гаруй байгууллагын төлөөлөл оролцож өнгөрсөн жилүүдэд “МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБОО”-оос зохион байгуулж хэрэгжүүлсэн ажил болон цаашдын зорилтын талаар тайланг хэлэлцэж, санал шүүмжлэл өрнүүлж салбарын өмнө тулгамдаж буй шийдвэрлэх шаардлагатай олон асуудлуудыг хөндөн ярилцаад энэхүү уриалгыг гаргаж өдөр тутмын сонин хэвлэл дээр нийтлүүлж, төрийн өндөрлөгүүдэд хүргүүлээ. ӨДРИЙН СОНИН 2013.06.18 МЯГМАР №153 (4480), ҮНДЭСНИЙ ШУУДАН 2013.06.13 ПҮРЭВ ГАРИГ №134 (1773)

Монголын ард түмний эрүүл, аюулгүй орчинд ая тухтай, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө тууштай хөдөлмөрлөж ирсэн нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарынхан тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэхэд төр засаг илүү анхаарах шаардлагатай байгааг тэмдэглэхийн сацуу дараах арга хэмжээг авах нь зүйтэй гэж үзэж байна.

- ❖ МНААҮ-ний салбарын өмнө тулгамдсан асуудлуудыг төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийн оролцоотой хэлэлцэж, цаашид авах арга хэмжээний талаар нэгдсэн ойлголцол, зөвшилцөлд хүрэх, шийдлийг гаргах зорилгоор МНААҮ-ний үндэсний чуулганыг 2013 оны 10 сард зохион байгуулах.
- ❖ Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний түүний дотор ус хангамж, ариутгах татуургын үнэ тарифыг удаан хугацаагаар, улс төрийн шалтгаанаар үндэслэлгүй аймаг, орон нутаг, нийслэлд барьж байсан нь тус салбарын байгууллагуудыг туйлдуулан, дампуурлын байдалд хүрсэнийг нэн яаралтай эдийн засгийн гольдролд оруулах.
- ❖ МНААҮ-ний салбарын ажилтан албан хаагчдын цалин хөлс бусад салбаруудынхаас хэт доогуур байгааг ойрын үед засч залруулах.
- ❖ НАА-н тусгай зөвшөөрөлтэй компаниудад дулааны шимтгэл олгох, дулааныг зохицуулалтаар хангах түгээх тусгай зөвшөөрөлд Эрчим хүчний зохицуулах хороо үндэслэлгүйгээр хягзаарлалт тогтоож байгааг болиулах.
- ❖ НААҮ-ний салбарт цаашид хийж хэрэгжүүлэх, зохион байгуулах зарим төрийн ажил үйлчилгээг ТББ-д хариуцуулан гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах

МНААҮХ-НЫ БҮХ ГИШҮҮДИЙН ЭЭЛЖИТ III ХУРАЛД ОРОЛЦОГСОД





НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ БҮЮУ БИДНИЙ АМИН ЧУХАЛ ХЭРЭГЦЭЭ

ОРШИЛ

Хүн ам, аж ахуйн нэгж байгууллагуудыг стандартад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулж, цэвэрлэх үйл ажиллагааг явуулдаг байгууллагуудыг манай улсад “Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагууд” гэж нэришиж ирсэн билээ. Үнэхээр ч энэ үйлчилгээ нь хүний тулгуур эрх болох ус уух эрхийг олгож, амин чухал хэрэгцээ, эрүүл тав, тухтай амьдрах гол нөхцөлүүдийг бүрдүүлдэг “нийтийн үйлчилгээ” юм. Монгол улсад 30-аад оны үеэс энэхүү үйлчилгээний үндэс суурь нь тавигдан, 90-ээд он хүртэл үйлчилгээний нэг салбарын хэмжээнд хөгжиж ирсэн байна. 90-ээд оноос улс оронд маань улс, төр, нийгэм, эдийн засгийн шинэчлэлт хийгдэж, зах зээлийн системд шилжих үед салбарын байгууллагууд шилжилтийн үеийн давалгаанд хөлөө алдахгүйг хичээн, хүндхэн цаг үеийг даван туулжээ.

Энэ ч аргагүй юм. Хүний амин чухал хэрэгцээ болсон ус хангамжийн үйлчилгээ нь зүй ёсны монопольд хамаарах нийтийн үйлчилгээний салбар учраас чөлөөт өрсөлдөөний хуулиар зохицуулагддаггүй, харин энэ үйлчилгээг аливаа улс орнуудад төрийн оролцоотой зохицуулдаг билээ. Гэвч зарим тохиолдолд төрийн энэхүү зохицуулалт нь хэт нэг талыг барьсан, улс төрийн нөлөөнд ордог тул усны үйлчилгээний үнэ тарифыг зохих түвшинд нь хүртэл зохицуулалт хийж чаддаггүйгээс энэ салбар биеэ даан хөгжихөд төвөгтэй болж, улмаар хамгийн хоцрогдмол байдалд ордог. Энэ байдлыг даван туулах хамгийн зөв шийдэл нь биеэ даасан хараат бус төрийн Зохицуулах байгууллага байгуулдаг явдал юм. Иймд Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк зэрэг санхүүгийн хандивлагч байгууллагуудын зөвлөмжийн дагуу манай улсад Хот суурины, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл (ХСУХАТАҮЗЗ) байгуулах тухай заалтыг Монгол Улсын Их хурлаар хэлэлцэн 2010 онд Хот суурины, ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд тусган баталснаар 2012 онд уг байгууллага байгуулагдсан билээ.

УСНЫ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ, ҮНДСЭН ЗОРИЛГО



Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл буюу Усны зохицуулах зөвлөл нь Монгол улсын хэмжээнд тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний үнийг



хянан батлах, усны үнэ тарифын бүтцийг тогтоох, аргачлал батлах, ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох чиг үүрэгтэйгээр байгуулагдсан юм. Байгууллагын үндсэн зорилго нь хүн амд хүргэх ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг чанаржуулах, стандартын түвшинд хүргэх, энэ үйлчилгээг эрхлэн явуулдаг байгууллагуудыг зах зээлийн орчинд үйл ажиллагааныхаа зардлыг нөхөж, алдагдалгүй ажиллах нөхцөлийг хангахуйц үнэ тарифын бодлогыг хэрэгжүүлэх, үнэ тарифыг бодит өртөг зардалд нь тулгуурлан тогтоох, улмаар эдгээр байгууллагуудын үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэж, өөрийн орлогоор хөрөнгө оруулалт, техник технологийн шинэчлэлтийг хийх боломжийг бүрдүүлэх явдал юм. Үүний тулд Монгол улсын Нийтийн аж ахуйн байгууллагуудад Усны үйлчилгээний менежментийн үндсэн зарчмуудыг нэвтрүүлэх, удирдлагын арга барилыг сайжруулах, олон улсад мөрдөгддөг үйлчилгээний чанарын стандартууд, гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг нэвтрүүлэх, тэдгээрийн ажлыг олон улсын бенчмаркинг үзүүлэлтүүдтэй харьцуулан дүгнэн ажиллах шаардлага урган гарч байна. Ингэснээр үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэж, үргүй зардлыг бууруулах боломж бүрдэнэ. Иймд Зохицуулах зөвлөл хэтийн зорилго, үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд эдгээр ажлуудыг тусган эхнээс нь хэрэгжүүлэн ажиллаж байна.

УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЕНЕЖМЕНТ БА САЛБАРЫН ХОЦРОГДОЛ

Хот, суурин байгуулагдан, хүн ам төвлөрөхийн хэрээр энэ үйлчилгээний хэрэгцээ, шаардлага улам бүр нэмэгдэж, Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх, салбарын бодлогыг



зөв тодорхойлох, бүтэц зохион байгуулалт, менежментийг сайжруулах тулгамдсан асуудлууд урган гарч байна. Манай Нийтийн аж ахуйн байгууллагууд нь үндсэндээ 50,60-аад оны үеийн бүтэц, удирдлага, зохион байгуулалтын арга барилаар, тэр үеийн хоцрогдож, хуучирсан техник технологиор зах зээлийн өнөө үед ажиллаж байгаа нь энэ салбарыг Ази, Африк, Латин Америкийн хөгжиж буй гэгдэж байсан улс орнуудаас ч хоцрогдмол байдалд оруулаад байгаа билээ.



Гэтэл олон зуун жилийн турш суурин, иргэншилтэй байгаа улс орнуудад ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ хөгжиж, үүний үрээр Усны үйлчилгээний менежментийн онол, арга зүй олон улсын практикт нэвтэрч, ус сувгийн байгууллагууд нь түүнийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Харин манай Нийтийн аж ахуйн байгууллагууд ёстой л “бор зүрхээрээ” хүн ардаа үйлчилж, “урд хормойгоороо хойд хормойгоо нөхөж” явна. Энэ юу гэсэн үг вэ гэвэл өнгөрсөн 2012 онд л гэхэд хөдөө орон нутгийн нийт 34 байгууллагын хувьд 3,1 тэрбум төгрөгийн, Улаанбаатар хотод УСУГ болон орон сууцны конторуудын хувьд 8,6 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд энэ мэтчилэн алдагдал жилээс жилд нэмэгдсээр салбарын хэмжээнд нийт хуримтлагдсан алдагдал 63 тэрбум төгрөг, урт хугацаат зээл, түүний хүүгийн төлбөр 110,4 тэрбум төгрөгт хүрээд байна. Салбарын мэргэжилтэй ажилчдын дундаж цалин хөдөө орон нутагт 330-370 мян.төг, Улаанбаатарт 450-500 мян.төг байгаа нь боловсон хүчний тогтвор суурьшилд сөргөөр нөлөөлж, мэргэжилтэй ажилчдын хомсдолд оруулжээ. Эдгээрийн үндсэн шалтгаан нь дээр өгүүлсэнчлэн үнэ тарифыг улс төрөөс хамааралтай тогтоодгоос, мөн сүүлийн хэдэн жил үнийн өсөлт, инфляцтай уялдуулан усны үнэ тарифыг өөрчлөөгүйтэй холбоотой. Тодруулбал одоогийн мөрдөж байгаа усны үнэ дунджаар усны байгууллагын үйл ажиллагааны буюу урсгал зардлын дөнгөж 60-70%-ийг нөхөхүйц хэмжээнд байгаа юм.

Дээрх тоо баримтуудаас гадна бодит байдал ямар байгааг цөөхөн хэдэн үгээр хэлмээр байна. Бид бараг бүгдээрээ Нийтийн аж ахуйн байгууллагаар үйлчлүүлдэг хэрэглэгчид. Орон сууцны хэрэглэгчдэд ус тасалддаг, зэвтэй ус гардаг, засвар үйлчилгээг цагт нь чанартай хийдэггүй гэсэн гомдол тасардаггүй бол гэр хорооллын иргэд усаа

холоос зөөвөрлөдөг, хязгаарлагдмал хэрэглээтэй байна. Түүнчлэн зарим газрын хүн ам гол горхи, булаг шанд, хувийн худгуудаас баталгаагүй ус ууж, хэрэглэж байна. Бохир ус татан зайлуулах тухайд бол байдал бүр хүнд. Төвлөрсөн системд холбогдоогүй бол хот, хөдөө хаана ч тэр бохир усаа ил задгай хаяж, ариун цэврийн наад захын шаардлага хангахгүй, хүний амьдрах орчин, байгаль, хөрс, усыг бохирдуулсаар байна. Улсын хэмжээгээр үйлдвэр болон ахуйн бохир ус цэвэрлэх нийт 125 байгууламж байгаагаас 43 нь бүрэн ажиллагаагүй болж 22-ийнх нь үйл ажиллагаа доголдож, байгаль, орчин тойрноо бохирдуулж байна.

Тэгэхээр дээрх асуудлууд ганц нэг нийтийн аж ахуйн байгууллагын асуудал биш, салбарын хөгжлийн асуудал бөгөөд үүнийг зөв, цогц бодлогоор шийдвэрлэх нь чухал юм.

Салбарын хөгжлийн бодлогыг зөв, оновчтой тодорхойлохын тулд асуудалд шинжлэх ухаанчаар хандах цаг болжээ. Бодлого боловсруулахад салбарын өнөөгийн нөхцөл байдал, газар нутаг, цаг уурын байдал, салбарын хөгжлийн түүх, уламжлалыг судалж суурь нөхцөлөө зөв тодорхойлох шаардлагатай. Үүнд манай эрдэмтэн, судлаачдын дуу хоолой чухал юм.

ХУВЬЧЛАЛ ХЭРЭГТЭЙ ЮУ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын хуулинд ус хангамж, ариутгах татуургын барилга, байгууламж, шугам сүлжээ нь төрийн болон орон нутгийн өмчид байна гэж заасан нь маш зөв зүйтэй заалт юм. Аливаа улс орнуудад, ялангуяа дэлхийн өндөр хөгжилтэй ихэнх орнуудад энэ нь төр, орон нутгийнхаа өмчид байдаг. Харин түүний ашиглалт,



үйл ажиллагааг хувийн болон төр, орон нутгийн өмчит компаниуд хариуцан явуулдаг байна. Үүнд Япон, Нидерланд, Америкийн дийлэнх мужууд, Канад, Герман, Итали, Франц, Сингапур зэргийг нэрлэж болно. Харин Англи, Америкийн зарим муж, цөөн хэдэн орнуудад хувийн өмчид байж түүнийг төрөөс зохицуулдаг. Учир нь 80-аад онуудад дэлхийн олон оронд Нийтийн аж ахуйн салбарыг хувьчилсан боловч энэ нь хэрэглэгчдийн эрх ашгийг хохироох, өмч хөрөнгийг үрэн таран хийх зэргээр олон муу үр дагаварт хүргэсэн тул төр үүнийг өмчдөө буцаан авсан байдаг. Бүтэц, зохион байгуулалт, төлөвлөлт, хяналтын механизмыг нь оновчтой, зөв шийдвэл өмчийн аль ч хэлбэр ашигтай сайн ажиллах



боломжтой боловч Нийтийн аж ахуйн хөрөнгө хувийн өмчид байх нь илүү эрсдэлтэй байдаг ажээ.

Төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)-ийн гэрээг хэрэгжүүлэх замаар хувийн хэвшлийн оролцоог хангах нь аль ч салбарт хэрэглэгдэж байгаа хамгийн түгээмэл арга болжээ. Хувийн хэвшлийн оролцоог нэвтрүүлэх нь төрийн ачааг хөнгөлж, салбарын үр ашгийг нэмэгдүүлэх сайн талтай ч хэт яаран, дутуу хийвэл ихээхэн хор уршигтай. ТХХТ-ийн гэрээ нь хувийн хэвшлийн оролцооны хувь хэмжээ, хугацаа, хариуцлагын байдал зэргээс хамааран олон хэлбэртэй байдаг. Манай улсад менежментийн хувьчлал нэг хэсэг моодонд орж төрийн өмчийг менежментийг гэрээгээр эзэмшүүлж байсан бөгөөд энэ нь Нийтийн аж ахуйн салбарт хэрэгжсэн хэдий ч төдийлөн үр дүнгээ өгөөгүй билээ. Үүний учир нь гэрээний наад захын шаардлага болох хариуцлагын тогтолцоо байхгүй, үйлчилгээний чанарыг ажлын үр дүнтэй холбоогүй, хугацаа тодорхойгүйгээс гадна гэрээний хяналтын тогтолцоо сул, эрсдлийг тооцоогүй зэрэгтэй холбоотой. Гэрээний олон төрлүүдээс хамгийн түгээмэл нь менежментийн гэрээ 3-5 жил, түрээсийн гэрээ 8-15 жил, концессийн гэрээ 20-30 жилийн хугацаатай байна. Менежментийн гэрээнд төр бүх хөрөнгө оруулалтаа хийж, эрсдлээ үүрдэг бол, концессийн гэрээний хувьд хувийн хэвшил төрийн өмчид хөрөнгө оруулалт хийж, түүнийхээ хэрээр эрсдлээ өөрөө хариуцдаг.

Манай салбарт төрийн зохицуулалтыг аль түвшинд, хэрхэн хэрэгжүүлэхээ шийдэхгүйгээр ТХХТ-ийг нэвтрүүлэх нь дэндүү хуумгай болно. Мөн салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгож бэлтгэлийг нь хангах хэрэгтэй. Манай зарим аймгуудад Азийн хөгжлийн банкны төслийн үйл ажиллагааны хүрээнд ТХХТ-ийг хэрэгжүүлэхээр оролдож байгаа боловч үүнд төрийн зохицуулалт, хууль эрх зүйн орчин зэрэг гадаад хүчин зүйлүүдээс гадна тухайн байгууллагын дотоод олон асуудлууд, үнэ тарифыг хүртэл зохих түвшинд хүргэх зэрэг асуудлыг шийдэхгүйгээр гаднаас хүчээр хэрэгжүүлэх нь үр дүнд хүрэхгүй юм.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БҮХ АСУУДЛЫГ ШИЙДЭХ ҮҮ

Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ нь зах зээлийн өрсөлдөөнөөр зохицуулах ёсгүй, төрийн зохицуулалттай байдаг зүй ёсны монополь салбар гэдгийг дээр нэгэнтээ өгүүлсэн билээ. Иймээс Нийтийн аж ахуйн байгууллагууд үнэ тарифаа өөрсдөө бие даан тогтоодоггүй, харин төрийн оролцоотой тогтоосоор ирсэн. Зохицуулах зөвлөл байгуулагдахаас өмнө үнэ тарифыг аймаг орон нутгаас нь бодит өртөг зардлыг нөхөхүйцээр тогтоож



байгаагүйгээс байгууллагууд хөрөнгө оруулалт, техник технологийн шинэчлэлт хийх нь бүү хэл засвар үйлчилгээгээ ч чанартай сайн хийх боломж байгаагүй байна. Иймээс эдгээр байгууллагууд нь урт хугацааны хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтгүй, зайлшгүй шаардлагатай үед гадны зээл тусламж юм уу, төрөөс хийгддэг, оруулсан хөрөнгө оруулалтын зардлыг үнэ тарифтаа тусгах, нөхөх асуудал байдаггүй зэрэг нь салбарыг ямар ч чадамжгүй, өр зээлд баригдсан салбар болгоод байна. Энэ байдлыг даруй засахын тулд үнэ тарифын бодлогыг оновчтой, зөв боловсруулах шаардлагатай бөгөөд үүнийг ХСУХАТАУЗЗ хийж эхлээд байна.

Түүнчлэн энэ жил шинэчлэлийн засгийн газраас Нийтийн аж ахуйн салбарт нэлээд хөрөнгө оруулалт, шинэчлэл хийхээр төлөвлөсөн нь үнэхээр чухал, шаардлагатай ажил мөн. Гэвч нөгөө талаар энэхүү хөрөнгө оруулалт нь байгууллагын зардлыг давхар нэмэгдүүлдэг тул үүнийг үнэ тарифтаа цаг алдалгүй тусгаж, элэгдлээ байгуулж байх хэрэгтэй байна. Ингэхгүй бол өмнөх алдааны үргэлжлэл болж магадгүй юм.

Үүнтэй холбогдуулан хэлэхэд 1990 оноос хойш Нийтийн аж ахуйн салбарт хийгдсэн Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Испаний Засгийн газрын зээлийн хөрөнгө оруулалт болох 110,4 тэрбум төгрөгний өрийг хэрхэн төлөх асуудал одоо болтол шийдэгдээгүй байна. Үнэ тариф нь урсгал зардлаа ч нөхөж чадахгүй байгаа өнөөгийн нөхцөлд салбарын байгууллагууд өөрсдөө төлнө гэвэл ёстой харганы ноосоор эсгий хийхийн үлгэр болно.

Цаашид энэ салбарт аль болох зээлээр хөрөнгө оруулалт хийхгүй байх, аливаа хөрөнгө оруулалтын үр өгөөжийг зохих журмаар нь тооцож байх, үнэ тарифтаа хөрөнгө оруулалтын зардлыг тусгадаг байх, хөрөнгө оруулалтын явцад хийдэг хяналт, шалгалтуудыг сайжруулах зайлшгүй шаардлага үүсээд байна. Түүнчлэн нэгэнт хийж байгаа хөрөнгө оруулалтад орчин үеийн, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, инженерийн зөв шийдлээр хийх, хөрөнгө оруулалтын үр дүнд ашиглалтын зардал буурч, өртөг, зардлаа богино хугацаанд нөхдөг байх зэрэг олон асуудлыг шийдвэрлэж байхыг нөхцөл байдал биднээс шаардаж байна. Ингэхгүйгээр урьд өмнөх шиг хэн нэгэн албан тушаалтан гадаадынхны аманд орж, тэдний хуучирч, хоцрогдсон техник технологийг борлуулдаг явдлыг таслан зогсоож чадахгүй юм.

Эцэст нь хэлэхэд иргэд бид ус тасалддаг, зэвтэй ус гардаг, бохир ус нь хальж орчин тойрон, байгалиа бохирдуулдаг үйлчилгээнд бус харин халуун, хүйтэн усан хангамж, бохир ус зайлуулах найдвартай систем бүхий орчин үеийн тохилог сууцанд тав тухтай амьдарч, үүнийхээ төлөө зохих төлбөрөө төлдөг болох ёстой. Энэ нь манай ХСУХАТАУЗЗ-ийн Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг зах зээлийн нөхцөлд үр ашигтай, орчин үеийн техник технологи, ажлын арга барилаар ажилладаг салбар болгох зорилтын үр дүн байх болно.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга
Ч.Эрдэнэчимэг



**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2013 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Усны үйлчилгээний суурь хураамж
батлах тухай

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10.1.1 дэх заалт, төвлөрсөн сүлжээнд холбогдсон орон сууцны айл өрх, албан газар, үйлдвэр, аж ахуйн нэгжийн хэрэглэгчдэд ус хангамжийн үйлчилгээг 24 цагаар тасралтгүй бэлэн байлгах нөхцлийг хангах шаардлагыг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Ус хангамжийн үйлчилгээг 24 цагаар тасралтгүй бэлэн байлгах усны үйлчилгээний суурь хураамжийн хэмжээг 1, 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү суурь хураамжийг 2013 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс мөрдөж ажиллахыг Нийслэл, орон нутгийн ус хангамж, ариутгах татуургын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт даалгасугай.

3. Ус хангамжийн үйлчилгээг тасралтгүй бэлэн байлгах, тасалдуулсан тохиолдолд суурь хураамжийг тооцох зааврыг батлуулж, мөрдүүлэх, энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын алба /Ж.Гэрэлчулуун/-нд үүрэг болгосугай.

ДАРГА
ГИШҮҮН



Ч.ЭРДЭНЭЧИМЭГ
Б.ЖИГЖИД
Ч.БАТТОГТОХ
С.ЧУЛУУНХУЯГ
Р.НЯМЖАВ

0000 0002 7



Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны 17 дугаар сарын 14-ны өдрийн 1/4 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт

УХА0506 5611547

Хүснэгт 1. Орон сууцны айл өрхийн усны үйлчилгээний суурь хураамжийн хэмжээ

НӨАТ-гүй төгрөгөөр

Улаанбаатар хот	Дархан, Эрдэнэт хот	Аймгийн төв 300 м ³ /хон-с дээш ус хэрэглээтэй сумын төв, суурин газрууд	300 м ³ /хон хүртэлх ус хэрэглээтэй сумын төв, суурин газрууд
2,000	2,000	1,800	1,000

Хүснэгт 2. Үйлдвэр, аж ахуйн нэгж, албан байгууллагын шугамын голчоос хамаарсан усны үйлчилгээний суурь хураамжийн хэмжээ*

НӨАТ-гүй төгрөгөөр

№	Оролтын шугамын голч*, мм	Суурь хураамж			
		Улаанбаатар хот	Дархан, Эрдэнэт хот	Аймгийн төв, 300 м ³ /хон-с дээш ус хэрэглээтэй сумын төв, суурин газрууд	300 м ³ /хон хүртэлх ус хэрэглээтэй сумын төв, суурин газрууд
1	15	5,500	5,000	4,500	3,500
2	20	7,500	6,900	6,200	4,800
3	25	11,500	10,500	9,500	7,500
4	32	17,100	15,600	14,000	11,000
5	40	25,500	23,200	20,900	16,500
6	50	40,100	36,500	32,100	26,000
7	65	49,800	45,400	40,800	
8	80	65,900	60,100	55,300	
9	100	95,500	87,100	82,000	
10	125	116,500	106,200		
11	150	158,100	145,000	130,500	
12	200	195,000	195,000		
13	250	268,800	268,800		
14	300	355,500	355,500		
15	400, түүнээс дээш	480,000	480,000	480,000	

*Тайлбар: Тоолуур суурилагдсан шугамын голчийг авч үзнэ.



ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10.1.1 дэх заалт, Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төвлөрсөн ус хангамжийн сүлжээнд холбогдсон орон сууцны айл өрх, үйлдвэр, аж ахуйн нэгж, албан байгууллагыг 24 цагаар усаар тасралтгүй хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Усны үйлчилгээний суурь хураамж мөрдүүлэх, ус тасарсан цагийг тооцох заавар"-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан зааврын дагуу усны үйлчилгээний суурь хураамжийг тооцож, 2013 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс мөрдөж ажиллахыг Нийслэл, орон нутгийн ус хангамж, ариутгах татуургын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Батлагдсан зааврын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Үнэ тарифын алба /Ж.Гэрэлчулуун/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Ч. ЭРДЭНЭЧИМЭГ

000000032



Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн даргын 2013 оны 07 дугаар сарын 10 -ны өдрийн 6/16 дугаар тушаалын хавсралт



УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ХУРААМЖ МӨРДҮҮЛЭХ, УС ТАСАРСАН ЦАГИЙГ ТООЦОХ ЗААВАР

1. Ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь усны үйлчилгээндээ суурь хураамж мөрдөхдөө энэхүү зааврыг удирдлага болгоно.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь Зохицуулах зөвлөлийн 2013 оны 7 сарын 09-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор батлагдсан усны үйлчилгээний суурь хураамжийг хэрэглэгчээс сар бүр зохих журмын дагуу тооцож авна.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төвлөрсөн ус түгээх, ариутгах татуургын сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд тухайн сард үйлчилгээний чанарыг хангаж, тасалдалгүй ажиллах бодит үр дүнгээс хамаарч суурь хураамжийн төлбөрийг тооцно.

4. Суурь хураамж нь тухайн сард үйлчилгээ үзүүлэхэд бэлэн байсан цаг хугацаатай уялдаатай байх, ТЗЭ-ийн үйл ажиллагаатай шууд холбоотойгоор хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж чадаагүй хугацааг тооцсон байх нөхцөлийг хангана. Хэрэглэгчийн суурь хураамжийг тогтоохдоо:

- Юуны түрүүнд оролтын шугамын голчийг харгалзан үзнэ.
- Хэрэглэгч оролтын шугамаас бага хэрэглэдэг тохиолдолд тоолуур суурилагдсан шугамын голчоор суурь хураамжийг тооцоолно.
- Дээрх 2-ын алийг ч хэрэглэх боломжгүй буюу тоолуургүй тохиолдолд хэрэглээнээс хамаарсан суурь хураамжийг мөрдөнө.

5. Ханган нийлүүлэгчийн ажлын гүйцэтгэлээс хамааран тухайн сард хэрэглэгчийн төлөх бодит суурь хураамжийг тооцно. Энэ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн сард төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээгээр хэрэглэгчийг хангасан хугацаанаас хамааран дараах хүснэгтийн дагуу тооцогдоно. Үүнд: Ус тасарсан тохиолдолд хэрэглэгчийн төлөх бодит суурь хураамжийн хэмжээг тогтоохдоо батлагдсан суурь хураамжийг хүснэгтэд үзүүлсэн хувь хэмжээгээр бууруулж авна.

Хүснэгт 1. Ханган нийлүүлэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас ус тасарсан хугацааг усны үйлчилгээний суурь хураамжид тооцох хувь хэмжээ

Ус тасарсан хугацаа, хоногоор	1-3	4-6	7-9	10-12	13-14	15-аас дээш
Суурь хураамжийг бууруулах хувь, %	15	30	40	60	80	100



6. Тухайн сард төлөх бодит суурь хураамжийг тооцохдоо зөвхөн тухайн ТЗЭ-ийн үйл ажиллагаатай шууд хамааралтай үйлчилгээний тасалдсан хугацааг хэрэглэгчдийн санал гомдлыг харгалзан тогтооно.

7. ТЗЭ-ийн төлөвлөгөөнд орж, хэрэглэгчдэд урьдчилан мэдэгдсэн засвар үйлчилгээний улмаас ус тасарсан хугацаа нь дээрх бууруулах хувь хэмжээнд хамаарахгүй.

8. Цахилгаан тасрах, бусад байгууллага, иргэдийн буруутай ажиллагааны улмаас болон байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлс зэрэг ТЗЭ-ийн өөрийнх нь үйл ажиллагаанаас хамааралгүйгээр үйлчилгээ тасалдсан тохиолдолд усны үйлчилгээний суурь хураамжийг хөнгөлөхгүй.

9. Хэрэглэгч нь 3 сараас дээш хугацаагаар үйл ажиллагаагаа зогсоох тохиолдолд 14 хоногийн өмнө албан бичгээр мэдэгдсэний үндсэн дээр суурь хураамжийн төлбөрөөс чөлөөлөгдөж болно.

Тухайн сард төлөх суурь хураамжийн төлбөр тооцох жишээ:

"Х" Компани нь "У" хотын 670 айл өрхөд цэвэр ус түгээх, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлдэг. Тус компани нь өнгөрсөн сард өөрийн ажилчдын буруугаас засвараа төлөвлөгөөт хугацаанд нь багтаалгүй 7 хоног хэтрүүлснээс ус хангамжийн үйл ажиллагаа тасалдсан байна. Тухайн хотын айл өрх тус бүрийн сарын суурь хураамж 2000 төгрөг болно.

Тус компанийн өнгөрсөн сарын суурь хураамжаас олох орлогыг тооцоолъё.

Үүний тулд "Х" компани үйл ажиллагаа явуулаагүй 7 хоногт ногдох суурь хураамжийг бууруулах хэмжээ 40 хувь байна.

Энэ тохиолдолд нэг өрхөөс авах тухайн сарын суурь төлбөр нь:

$$C_v = 2000 - 2000 * 40\% = 1200 \text{ төг}$$

Нийт айл өрхөөс авах сарын суурь хураамжийн нийт орлого:

Тухайн сарын компанийн орлого = $670 * 1200 = 840.0$ мян.төг болно.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 7 ДУГААР САРЫН 16 ДУГААР ХУРАЛДААНААР: “ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРҮҮДИЙН ТЕХНИК, САНХҮҮ-ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ИМПОРТЫН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМЖЭЭ ӨСЧ БАЙГАА ЗЭРЭГТ ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ ӨГЧ, ХЭРЭГЛЭГЧИЙН ХЭРЭГЛЭЭНД ЗОХИХ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ ХИЙСНИЙ ҮНДСЭН ДЭЭР ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ, ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН “УХААЛАГ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖСЭН” ҮНЭ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ ШИЙДВЭР ГАРГАЛАА.



ЭХЗХ-ны дарга С.Отгонбаярын сэтгүүлчдэд тайлбарласнаар цахилгаан, дулааны үнийг нэмэх шийдвэр “ухаалаг хэрэглээг дэмжих” зорилготой аж. “Ухаалаг хэрэглээг дэмжих” шинэ зохицуулалтаар Улаанбаатар хотын орон сууцанд амьдардаг айл өрхүүд 150квт цагаас бага эрчим хүч хэрэглэсэн бол 79 төгрөг /одоо мөрдөгдөж байгаа тарифаар 74 төгрөг, 151квт цагаас дээш болвол 96 төгрөгөөр /одоо мөрдөж байгаа тарифаар 79 төгрөг тооцуулан төлбөрөө төлөх ажээ. Гэр хорооллын айл өрхийн цахилгааны тариф орон сууцны өөхийн тарифаас

тус бүр гурван төгрөгөөр хямд байсан ч ЭХЗХ-ны тайлбарласнаар ижил болж байгаа бололтой. Гэхдээ эдгээр үнэд НӨАТ ороогүй гэдгийг онцолъё.

Аж ахуйн нэгж байгууллагуудын цахилгааны үнийг хорин хувиар нэмжээ. Одоо мөрдөж байгаа тарифаар аж ахуйн нэгжүүд өдрийн хэрэглээндээ нэг квт цагт 88 төгрөг, оройн ид ачааллын үе буюу 17.00-22.00 цагийн хооронд 155.20 мөнгө, харин шөнөдөө 46 төгрөг төлж байгаа юм. Уул уурхайн компаниудад цахилгааны тусдаа тариф үйлчилдэг бөгөөд энэ тарифийг 30 хувиар нэмсэн байна. Уул уурхайн компаниуд өдрийн цагаар нэг квт цагт 100 төгрөг, оройн ачааллын үед 179.40 мөнгө, шөнөдөө аж ахуйн нэгжүүдтэй адил тарифаар төлдөг байна. Эдгээр үнэд мөн адил НӨАТ ороогүй үнэ юм.

Харин дулааны үнийн хувьд айл өрхүүдийн дулааны үнэд суурь үнэ гэсэн шинэ зүйлийг бий болгож байгаа аж. Өөрөөр хэлбэл, амьдран сууж буй орон сууцны талбайн хэмжээнээс хамаарч хэрэглэсэн дулааны үнэн дээрээ нэмж суурь үнэ төлөхөөр болж байна. 25-40 м.кв орон сууцанд амьдрагч өрх 3000, 41-ээс 80 м.кв орон сууцанд амьдардаг бол 5000, 81-ээс дээш м.кв орон сууцтай бол 10.000 төгрөг нэмж төлөхөөр болж байна.

С.ЦЭЦГЭЭ: ЭРЧИМ ХҮЧНИЙ КОМПАНИУДЫГ АЛДАГДАЛГҮЙ БОЛГОХ ГЭЖ ТАРИФ ТОГТООДОГГҮЙ

Эрчим хүчний зохицуулах хорооноос хэрэглэгчдийг үр ашигтай эрчим хүчний хэрэглээнд шилжүүлэхэд чиглэсэн үнийн шинэ зохицуулалтыг баталсан. Шинэ зохицуулалтаар, цахилгаан эрчим хүчний үнийг цагаар биш, хэрэглээний хэмжээгээр зохицуулахаар заасан байна. Тодруулбал сардаа 150 кВт цахилгаан эрчим хүчний хэрэглээтэй өрхийн эрчим хүчний үнийг одоо мөрдөгдөж байгаа үнээр нь үлдээж, 79 төгрөг байхаар тогтоожээ. Харин 150-аас дээш хэрэглээтэй өрхийн эрчим хүчний үнийг 96 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон байна. Энэхүү шинэ зохицуулалтын талаар Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулалтын газрын дарга С.Цэцгээгээс тодрууллаа.





-Үнэ нэмэх шийдвэрийг ямар шалтгаанаар гаргав. Энэ талаар тодруулаач?

-Тэгэхээр нөхцөл байдал үнэ нэмэх шалтгааныг бий болгож байна. Эрчим хүчний компаниудын алдагдлыг бууруулах гэж үнэ нэмж байна гэсэн буруу ойлголт нийгэмд төрөөд байгаа юм. Эрчим хүчний зохицуулах хороо эрчим хүчний компаниудын бүх үйл ажиллагааны зардлаар тариф тогтоодоггүй. Зөвхөн цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, үйл ажиллагааны шаардлагатай зардалд тариф тогтоодог. Тийм учраас үрэлгэн зардлыг бүхэлд нь тариф болгож, ард түмний нуруун дээр үүрүүлэх гэж байна гэдэг нь гажуу ойлголт юм. Ер нь бол эрчим хүчний үнийг нэмэх бодитой шаардлага бий болсон. Төвийн эрчим хүчинд суурилагдсан хүчин чадал 793 МВт байна. Харин өнгөрсөн нэгдүгээр сард 875 МВт хүрсэн. Ирэх өвөл 960 МВт-д хүрэх гэж байна. Бид асар их хэмжээний импортын эрчим хүч авч байгаа. Одоогоор 355 сая орчим кВт цахилгаан эрчим хүч авч байна. Цаашдаа шинэ эх үүсвэртэй болохгүй бол энэ хэмжээ нэмэгдэх хандлагатай байгаа. Импортоор авч байгаа цахилгаан эрчим хүчний үнийн хувьд, дунджаар 127-128 төгрөг байдаг. Үүн дээр түгээх, дамжуулах үйл ажиллагааны зардал гэж 46 орчим төгрөг нэмэгдэнэ. Ингэхээр үндсэндээ бодит өртөг нь 170 орчим төгрөг болж байгаа юм. Тиймээс хэрэглэгчдэд импортоор орж ирж байгаа өндөр үнэтэй эрчим хүчийг ядаж худалдаж авах үнээр нь борлуулна гэсэн байр суурьтай байгаа юм.

-Айл өрхийн хувьд хэр зэрэг дарамт учруулах бол?

-Айл өрхийн хүрээнд олон төрлийн тариф мөрдөж байсан. Улаанбаатар хотын хэрэглэгчид орон сууц болон гэр хорооллоороо ялгагддаг. Эрчим хүчний зохицуулах хорооны гол байр суурь бол хэрэглэгчийг биш хэрэглээг аюулгүй болгох ёстой гэдэг үүднээс улс орон даяар төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдсон хэрэглэгчид маань 150 кВт цахилгаан эрчим хүчинд 79 төгрөг төлнө. Харин 150-аас дээш кВт эрчим хүчний үнийг 96 төгрөг 60 мөнгө байхаар шинэчлэн тогтоосон. 150 кВт нь ахуйн хэрэглээний наад захын хэрэглээг бүрэн хангах хэмжээнд байдаг. Смарт тоноглолуудыг авч хэрэглэлээ гэж бодоход, дунджаар дөрвөн ам бүлтэй айлын хэрэгцээг бүрэн хангана. Тэгэхээр ахуйн хэрэглээнд дарамт өгөхгүй гэж үзэж байгаа. Нөгөө талаас хэрэглээ өндөртэй газарт хэмнэлт хийх бололцоо асар их байдаг. Ахуйн хувьд зохих хэмжээний хэрэглээг хангах үнийг хэвээр нь үлдээе. Харин түүнээс цаашихад нь тодорхой хэмжээний үнийн өсөлт байх ёстой гэж үзэж байгаа юм. Тиймээс ахуйн хэрэглээндээ авч буй цахилгаан хэрэгслээ ямар хэмжээний чадал хэрэглэх вэ гэдгийг нь судалж худалдаж авах хэрэгтэй.

-Эрчим хүчний үнэ нэмэгдсэнээр бусад бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтөд нөлөөлөх үү?

-Үнэ нэмнэ гэдэг ер нь харьцангуй ойлголт. Зохицуулах хорооны зүгээс цахилгаан дулаан үйлдвэрлэхэд ямар хэмжээний зардал шаардлагатай байна вэ гэдэг тарифаар үнэ тогтоодог. Түүнээс биш тухайн

компаниудыг алдагдалгүй болгох гэж тариф тогтоодоггүй. Тийм учраас үрэлгэн зардал зэрэг эрчим хүчний бусад тарифтай холбож ойлгож болохгүй. Хэрэглэгчдэд ямар дарамт учрах вэ гэдгийг авч үзье. Эрчим хүчний үнийг хүчээр бариад байвал нийгэмд тогтож байгаа бүх үнэ худлаа болж эхэлнэ. Өөрөөр хэлбэл эдийн засгийн бодит үнэ биш болж эхэлж байгаа юм. Үүнээс гадна эдийн засагт хэрэглэгчийн урсгалд нөлөөлөх нөлөөллийг үздэг шинжилгээний аргууд байдаг. Тухайлбал мэдрэмжийн тухай асуудал энд яригдана. Хэрвээ эрчим хүчний үнэ тухайн компанийн үйл ажиллагаанд зохих хэмжээнд нөлөөлөхүйц хэмжээнд байвал тухайн компанийн эрчим хүч худалдан авалт нь буурч эхэлдэг. Сүүлийн арваад жилийн дотор эрчим хүчний үнэ дөрвөн удаа хөдөллөө. Энэ үед аль ч төрлийн хэрэглээнд хэрэглэгчийн хэрэглээ буурч байгаагүй. Тэгэхээр өнөөдрийн байдлаар жижиг зах зээл дээр эрчим хүчний үнэ нэмэгдлээ гэж тайлбарлаж байгаа болохоос энэ нь эдийн засагт бодитой нөлөөлж байгаа сөрөг хандлага гэж үзэхгүй байна.

-Тарифыг нэмснээр эрчим хүчний алдагдал хэдэн хувиар буурах бол?

-Өнгөрсөн жил үндсэн үйл ажиллагааны хувьд, 66.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан. Тарифын санал ирүүлсэн компаниудын саналыг нэгтгээд үзэхэд, хэрвээ тухайн компанийн нэхэж байгаа зардлаар өгч чадахгүй гэж үзвэл 130-аад тэрбум төгрөгийн алдагдалтай гарахаар харагдаж байгаа. 130 тэрбум төгрөгийг тэр чигт нь хэрэглэгчийн тарифт суулгах ямар ч бололцоо байхгүй. Сая бидний хийсэн тарифын зохицуулалтаар үндсэндээ 70 орчим тэрбум төгрөгийн асуудлыг ярьж байгаа. Тэгэхээр үлдэж байгаа 60 орчим тэрбум төгрөгийн асуудлыг эрчим хүчний компаниуд өөрсдөө хариуцна. Өөрөөр хэлбэл хэмнэлт, дотоод хэрэгцээ, бусад зардлаа бууруулах зэрэг арга хэмжээг компаниуд өөрсдөө хариуцах ёстой юм.

-Эрчим хүч гэнэт тасарч, доголдох тохиолдол олон гардаг. Энэ үед хаана хандах ёстой байдаг вэ?

-Зохицуулах хорооноос баталсан нэг дүрэм бий. Иргэн Доржтой гэрээ байгуулахдаа эрчим хүчээр хангах гэрээ байгуулдаг. Тэрхүү гэрээнд эрчим хүчний доголдол аваар ослын улмаас тоног, төхөөрөмж гэмтвэл түүний шууд хохирлыг буруутай байгууллага хариуцна гэж заасан байдаг. Харамсалтай нь хэрэглэгчдийн хувьд, хууль эрх зүйн мэдлэг дутуу зэрэг шалтгаанаар хохирлын хэмжээг тогтоодоггүй. Мөн төдийлөн мэдрэмжтэй бус тоноглолууд хэрэглэж байгаа учраас хохирлын том тоо гардаггүй.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2013 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 70

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг үндэслэн “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-иас ирүүлсэн хүсэлтийг авч хэлэлцээд Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үйлчилгээний тарифыг хавсралтын ёсоор баталсугай.
2. Батлагдсан тарифыг 2013 оны 08 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн мөрдөх, хэрэглэгчидтэй байгуулсан гэрээндээ тусгаж ажиллахыг Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны Зохицуулалтын газар /С.Цэцгээ/-т даалгасугай.


ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ



С.ОТГОНБАЯР

Н.МЯГМАРСҮРЭН

Д.БАССАЙХАН

Д.ЧУЛУУНБААТАР

Д.ЖАРГАЛСАЙХАН

**УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ****1. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага**

№	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалт	Төг/м ³	323
		Төг/Гкал	20,886
		Төг/ГДж	4,989
2	Салхилуулга	Төг/Гкал	10,632
		Төг/ГДж	2,539
3	Албан байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/хүн	4,084
4	Технологийн халуун ус	Төг/Гкал	10,632
		Төг/ГДж	2,539

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагад борлуулах дулааны уурын тариф	Төг/Гкал	15,500.0
		Төг/ГДж	3,699.0

2. Айл өрх

№	Хэрэглэгчдийн ангилал		Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "О"-ын өрөөний халаалт хамаарна)		Төг/м ²	341
			Төг/Гкал	7,879
			Төг/ГДж	1,882
2	Хүний тоогоор	Халаалтын улиралд	Төг/хүн	1,282
		Халаалтын бус улиралд	Төг/хүн	1,924
	Хэмжүүрээр		Төг/Гкал	9,824
			Төг/ГДж	2,346

Улаанбаатар хотын ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф

Ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үйлчилгээний тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	40 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	3,000.00
2	41 м ² -аас 80 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	5,000.00
3	81 м ² -аас дээш талбайтай айл өрх	Төг/сар	10,000.00



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2013 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

Хэрэгцээний халуун усыг халаасан дулааны төлбөрийг тогтоох тухай

Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг үндэслэн “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-иас ирүүлсэн хүсэлтийг авч хэлэлцээд Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд ус, дулаан дамжуулах төвөөс хэрэгцээний халуун усаар хангагдаж, орон сууцны байр болон өргөтгөлд аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа хэрэглэгчдийн хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг дараах байдлаар тооцсугай. Үүнд:

1.1 Кафе, цайны газрын хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 0,15 Гкал/сар (0,63ГДж/сар)-аар тооцон суудлын тоогоор үржүүлж,

1.2 Үсчин гоо сайхны газрын хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 1,93 Гкал/сар (8,08 ГДж/сар)-аар тооцон суудлын тоогоор үржүүлж,

1.3 Хүнсний дэлгүүр, компьютер тоглоомын газрын хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 2,45 Гкал/сар (10,26 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж,

1.4 Сауны хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 2,08 Гкал/сар (8,62 ГДж/сар)-аар тооцон шүршүүр, тосгуурын тоогоор үржүүлж,

1.5 Эмийн сангийн хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 2,07 Гкал/сар (8,67 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж,

1.6 Зочид буудлын шүршүүр, тосгуур бүхий өрөөний 1 оронд ногдох хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 0,28 Гкал/сар (1,17 ГДж/сар)-аар тооцон орны тоогоор үржүүлж,

1.7 Амбулаторийн хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 1,93 Гкал/сар (8,08 ГДж/сар)-аар тооцон суудлын тоогоор үржүүлж,

1.8 Эмнэлгийн хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 0,68 Гкал/сар (2,85 ГДж/сар)-аар тооцон орны тоогоор үржүүлж,



1.9 Оёдол, цэцгийн дэлгүүр, кино прокат, гар урлалын зориулалттай байрны хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 0,055 Гкал/сар (0,23 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж,

1.10 Гурилын цехийн зориулалттай байрны хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 0,27 Гкал/сар (1,13 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж,

1.11 Ундааны цехийн зориулалттай байрны хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 0,66 Гкал/сар (2,76 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж,

1.12 Шил угаах цехийн зориулалттай байрны хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 1,3 Гкал/сар (5,44 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж,

1.13 Бууз, баншны цехийн зориулалттай байрны хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 0,18 Гкал/сар (0,67 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж,

1.14 Сургууль, цэцэрлэгийн зориулалттай байрны хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 1,0 Гкал/сар (4,19 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж,

1.15 Зайрмагийн цехийн зориулалттай байрны хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 1,0 Гкал/сар (4,19 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж,

1.16 Албан контор, хими цэвэрлэгээний хүлээн авах цэг, барьцаалан зээлдүүлэх, бичиг баримт хувилж олшруулах үйл ажиллагаа явуулж байгаа байрны хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 0,11 Гкал/сар (0,46 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж,

2. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд ус, дулаан дамжуулах төвөөс хэрэгцээний халуун усаар хангагдаж, энэ тогтоолын 1 дүгээр заалтад заасан орон сууцны байр болон өргөтгөлд аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа хэрэглэгчдийн хэрэгцээний халуун усыг халаасан 1 Гкал (1 ГДж) дулааны төлбөрийг 20,886.00 төг/Гкал (4,989.00 ГДж)-аар тооцсугай.

3. Цаашид хэрэглэгчдийн хэрэглэсэн хэрэгцээний халуун усыг халаасан дулааны тоолуурыг шинээр баригдах барилга, байгууламжийн техникийн нөхцөл, зураг төсөлд тусгаж байхыг “Улаанбаатарын дулааны сүлжээ” ТӨХК /Р.Хайдав/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолыг 2013 оны 8 дугаар сарын 6-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компани, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /гүйцэтгэх захирал, захирал, дарга нар/-т даалгасугай.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны Зохицуулалтын газар /С.Цэцгээ/-т даалгасугай.



6. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах газрын Зохицуулагчдын зөвлөлийн “Хэрэгцээний халуун усыг халаасан дулааны төлбөрийг тогтоох тухай” 2011 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн 95 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ



С.ОТГОНБАЯР

Н.МЯГМАРСҮРЭН

Д.БАССАЙХАН

Д.ЧУЛУУНБААТАР

Д.ЖАРГАЛСАЙХАН



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ

1. Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт	Төг/м ³	298.00
		Төг/Гкал	16,600.00
		Төг/ГДж	3,965.00
2	Технологийн халуун ус	Төг/Гкал	9,180.00
		Төг/ГДж	2,192.00
3	Албан байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/хүн	3,142.00
		Төг/тн	1,045.00
		Төг/Гкал	6,848.00
		Төг/ГДж	1,636.00
4	Уур 8-13 ата	Төг/Гкал	20,000.00
		Төг/ГДж	4,777.00
5	Уур 20 ата	Төг/Гкал	24,500.00
		Төг/ГДж	5,852.00

2. Ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "О"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ²	341.00
		Төг/Гкал	7,879.00
		Төг/ГДж	1,882.00
2	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Хаалттай Төг/хүн	1,282.00
		Нээлттэй Төг/хүн	1,924.00
3	Ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф		
3.1	40 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	3,000.00
3.2	41 м ² -аас 80 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	5,000.00
3.3	81 м ² -аас дээш талбайтай айл өрх	Төг/сар	10,000.00



ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ

1. Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт	Төг/м ³	345.00
		Төг/Гкал	22,556.00
		Төг/ГДж	5,387.00
2	Салхилуулга	Төг/Гкал	8,730.00
		Төг/ГДж	2,085.00
3	Албан байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/хүн	4,538.00
4	Технологийн уур	Төг/Гкал	24,500.00
		Төг/ГДж	5,852.00

2. Ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "О"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ²	341.00
		Төг/Гкал	7,879.00
		Төг/ГДж	1,882.00
2	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Халаалтын улиралд Төг/хүн	1,282.00
		Халаалтын бус улиралд Төг/хүн	1,924.00
3	Ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф		
3.1	40 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	3,000.00
3.2	41 м ² -аас 80 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	5,000.00
3.3	81 м ² -аас дээш талбайтай айл өрх	Төг/сар	10,000.00



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2013 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг үндэслэн, тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлсэн хүсэлтийг хянан хэлэлцээд Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Төв, Зүүн, Өмнөд, Алтай-Улиастайн бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон үйлдвэр, аж ахуйн нэгж болон бусад байгуулагад борлуулах цахилгааны тарифыг нэгдүгээр хавсралтын, айл өрхөд борлуулах цахилгааны тарифыг хоёрдугаар хавсралтын, ахуйн тоолуургүй цахилгаан хэрэглэгчдийн төлбөр тооцох сарын дундаж хэрэглээг гуравдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Батлагдсан тарифыг 2013 оны 8 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн мөрдөх, хэрэглэгчидтэй байгуулсан гэрээндээ тусгаж ажиллахыг дараах цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид, тэдгээрийн удирдлагад үүрэг болгосугай.

- 2.1 “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК /С.Төмөрхүү/
- 2.2 “Эрдэнэт, Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК /Ч.Баттуяа/
- 2.3 “Багануур-Зүүн Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК /Ш.Доржрагчаа/
- 2.4 “Дархан, Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХХК /С.Нэргүй/
- 2.5 Монгол-Оросын хамтарсан “Улаанбаатар төмөр зам” Нийгэмлэг /Г.Сэрээнэндорж
- 2.6 Үйлдвэрлэл, худалдаа -үйлчилгээний “Нолго” ХХК /П.Батчулуун/
- 2.7 “Эрчим сүлжээ” ХХК /Е.Амаржаргал/
- 2.8 “Баянхонгор- Эрчим хүч” ОНӨЦТК /М.Батбаяр/
- 2.9 “Хөвсгөл- Эрчим хүч” ОНӨХХК /М.Пүрэвсүрэн/
- 2.10 “Эрдэнэт- Амьдрал” ХХК /Ч.Мягмарсүрэн/
- 2.11 “Пауэр юнит” ХХК /П.Жаргалсайхан/
- 2.12 “Дулааны II цахилгаан станц” ТӨХК /С.Бямбаахүү/
- 2.13 “Дулааны III цахилгаан станц” ТӨХК /Г.Дамдинсүрэн/
- 2.14 “Дулааны IV цахилгаан станц” ТӨХК /Б.Цэвээн/
- 2.15 “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК /Ч.Чинбат/
- 2.16 “Алтай- Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК /Г.Чинбат/
- 2.17 “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК /Ж.Дорж/



3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны Зохицуулалтын газар /С.Цэцгээ/-т даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах газрын Зохицуулагчдын зөвлөлийн “Тариф батлах тухай” 2008 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 101 дүгээр тогтоол, “Тариф батлах тухай” 2010 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 111 дүгээр тогтоол, “Тариф батлах тухай” 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 92 дугаар тогтоолын хавсралтын 1, 3 дугаар заалтууд, “Тариф батлах тухай” 2011 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 14 дүгээр тогтоол, “Тариф батлах тухай” 2011 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 18, 19, 20 дугаар тогтоолуудын хавсралтын 1 дүгээр заалтууд, 2011 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 21 дүгээр тогтоолын хавсралтын 1, 2, 3 дугаар заалтуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ



С.ОТГОНБАЯР

Н.МЯГМАРСҮРЭН

Д.БАССАЙХАН

Д.ЧУЛУУНБААТАР

Д.ЖАРГАЛСАЙХАН



ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖ БОЛОН БУСАД БАЙГУУЛЛАГАД БОРЛУУЛАХ ЦАХИЛГААНЫ ТАРИФ

Энэхүү тариф нь 2013 оны 08 дугаар сарын 05-ний өдрөөс эхлэн мөрдөгдөнө.

Үйлдвэр, аж ахуйн нэгж болон бусад байгууллагад борлуулах цахилгааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно:

№	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр		
	Үүнд: <ul style="list-style-type: none"> • Нүүрс олборлолт, боловсруулалт • Газрын тос, шатдаг хий олборлолт, боловсруулалт • Төмрийн хүдэр олборлолт, боловсруулалт • Бусад ашигт малтмал олборлолт, боловсруулалт 		
1.1	Энгийн тоолууртай	Төг/кВт.ц	130.00
1.2	3 тарифт тоолууртай		
а	Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 17.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	130.00
б	Оройн хэрэглээ /оройн 17.00 цагаас шөнийн 24.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	210.00
в	Шөнийн хэрэглээ /шөнийн 24.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	60.00
2	Бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага		
2.1	Энгийн тоолууртай	Төг/кВт.ц	105.60
2.2	3 тарифт тоолууртай		
а	Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 17.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	105.60
б	Оройн хэрэглээ /оройн 17.00 цагаас шөнийн 24.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	178.60
в	Шөнийн хэрэглээ /шөнийн 24.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	60.00
2.3	"Цахилгаан тээвэр" ХК	Төг/кВт.ц	60.00
3	Улаанбаатар хот, аймгийн төвийн нийтийн зориулалттай зам талбайн гэрэлтүүлэг болон нийтийн зориулалттай орон сууцны орцны гэрэлтүүлэг		
3.1	10, 11, 12, 1, 2, 3 дугаар саруудад		
а	Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 19.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	105.60
б	Орой, шөнийн хэрэглээ /оройн 19.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	60.00
3.2	4, 5, 6, 7, 8, 9 дүгээр саруудад		
а	Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 22.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	105.60
б	Орой, шөнийн хэрэглээ /оройн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	60.00



АЙЛ ӨРХӨД БОРЛУУЛАХ ЦАХИЛГААНЫ ТАРИФ

Энэхүү тариф нь 2013 оны 08 дугаар сарын 05-ний өдрөөс эхлэн мөрдөгдөнө.

1. Айл өрхөд борлуулах цахилгааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно:

№	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Энгийн тоолууртай		
а	Сарын нийт хэрэглээ 150 кВт.ц хүртэл хэрэглээг	Төг/кВт.ц	79.00
б	Сарын нийт хэрэглээ 151 кВт.ц болон түүнээс дээшхи хэрэглээг	Төг/кВт.ц	96.60
2	2 тарифт тоолууртай		
а	Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас шөнийн 21.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	84.00
б	Орой, шөнийн хэрэглээ /оройн 21.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	60.00
3	Сарын суурь тариф	Төг/сар	1000.00

2. Ахуйн тоолуургүй цахилгаан хэрэглэгчдийн төлбөр тооцох сарын дундаж хэрэглээг төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Сарын хэрэглээ
1	Айл өрх	кВт.ц	350.00

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ЦАХИЛГААН, ДУЛААНЫ ТАРИФ

1. Импортын цахилгаан эрчим хүчээр хангагдаж буй хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага		
1.1	Халх гол сум /импорт/	Төг/кВт.ц	100.00
1.2	Эрдэнэцагаан сум /импорт/ ¹	Төг/кВт.ц	100.00
1.3	Чулуунхороот /импорт/ ²	Төг/кВт.ц	100.00
2	Айл өрх		
2.1	Халх гол сум /импорт/	Төг/кВт.ц	100.00
2.2	Эрдэнэцагаан сум /импорт/	Төг/кВт.ц	100.00
2.3	Чулуунхороот /импорт/	Төг/кВт.ц	100.00

[1] Эрдэнэцагаан сумын дэд станцын 35 кВ, 10 кВ талаас болон 35 кВ-ын ЦДАШ-наас шинээр холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудад хамаарахгүй.

[2] Чулуунхороот сумын 10 кВ-ын ЦДАШ-наас шинээр холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудад хамаарахгүй.



2. Хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф	
1	Үйлдвэр, аж ахуйн нэгжийн халаалт	Төг/м ³	527.00	
2	Хэмжүүрээр тооцох дулаан	Төг/Гкал	19,236.00	
		Төг/ГДж	4,594.00	
3	Орон сууцны халаалт	Төг/м ²	341.00	
4	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан (Хүний тоогоор)	Халаалтын улиралд	Төг/хүн	1,282.00
		Халаалтын бус улиралд	Төг/хүн	1,924.00
5	Ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф			
5.1	40 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	3,000.00	
5.2	41 м ² -аас 80 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	5,000.00	
5.3	81 м ² -аас дээш талбайтай айл өрх	Төг/сар	10,000.00	

“БАРУУН БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ЦАХИЛГААН, ДУЛААНЫ ТАРИФ

“Улаангомын цахилгаан шугам сүлжээний газар”, “Ховд цахилгаан түгээх сүлжээ”, “Баян-Өлгийн цахилгаан шугам сүлжээний газар” компаниудын хэрэглэгчдэд борлуулах цахилгааны үнэ 2002 оны IX/15-ны 88, 89, 90 дүгээр тогтоолуудын дагуу 2002 оны VII/01-с мөрдөгдөж байгаа.

1. Цахилгааны тариф

№	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага	төг/кВт.ц	90.0
2	Айл өрх	төг/кВт.ц	60.0

2. Ахуйн хэрэгцээнд тоолуургүй нөхцөлд хэрэглэсэн цахилгааны тариф

№	Ангилал	Хэмжих нэгж	Үнэ /НӨАТ-гүй/	
			Айл өрх	ТҮЦ, гараж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг айл өрх
1	Залгуур /1 ширхэг/	төг/сард	9725	19,450.0
2	Гэрлийн шил			
	25 Вт /1ширхэг/	төг/сард	365	730.0
	40 Вт	төг/сард	595	1,190.0
	60 Вт	төг/сард	905	1,810.0
	75 Вт	төг/сард	1139	2,278.0
	100 Вт	төг/сард	1502	3,004.0
	150 Вт	төг/сард	2251	4,502.0
	200 Вт	төг/сард	3007	6,014.0
	500 Вт	төг/сард	7520	15,040.0
	1000 Вт	төг/сард	15203	30,406.0



ИПОТЕКИЙН ЗЭЭЛ, ҮНИЙН ХӨӨС

Б.Мөнхзаяа /Ph.D./

/СЭЗДС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхмийн багш/

1. Үүсэл хөгжил

Ипотекийн зээл гэдэг нь орон сууц барьцаалсан урт хугацаат зээл ба зээлдэгч орон сууцдаа амьдарч байхдаа зээлээ төлдөг онцлогтой. Ипотекийн зээлийг АНУ болон зарим улсуудад “Моргейж” гэж нэрлэдэг ба латинаар “Мор” гэдэг нь “Үхэл”, “Гейж” гэдэг нь “Ямар нэгэн зүйлийн төлбөрийг өгч чадахгүйд хүрвэл оронд нь үнэ цэнэтэй зүйлээ битүүмжлүүлэх” гэсэн утгатай. Тиймээс “Mortgage” гэдэг үгийг “Үхлийн гэрээ” гэж тайлбарладаг. Европын суурьшигчид Америкт шилжиж ирэх үедээ өөрсдийн моргейжийн системээ мөн хамтад нь авчирсан. Газрын эзэд нэмэгдэхийн хэрээр моргейжийн эрэлт хэрэгцээ өсч 1900 он хүртэл газар авчээ. Ямар нэгэн өмчлөлтэй болох гэж байгаа хэн боловч урьдчилгаа төлбөр болох 50 хувийг өөрөөсөө санхүүжүүлж үлдсэн 50 хувийг зээлдэгчээс таван жилийн хугацаатайгаар авдаг байв. Таван жилийн дараа бүх зээлсэн мөнгө төлөгдсөн байх ёстой бөгөөд хэрэв төлөгдөөгүй байвал хөрөнгийг хурааж авна. Зээлийн энэхүү нөхцөл нь хэтэрхий хатуу бөгөөд нийт хүн амын 40 хувь нь хамрагдаж чаддаг байсан. Энэ систем нь зээлдэгч, зээлдүүлэгч аль аль нь ямар ч мөнгөгүй болсон үе болох “Их Хямрал”-ын үед ч хэрэгжсээр л байв. “Их Хямрал”-ын үед байшин худалдан авагчид бэлэн мөнгөний хомсдолд орсон тул урьдчилгаа төлбөрийг зарж буй байрны үнийн дүнгийн 30 хувиар, хугацааг 5-10 жил болгож сунгах, зээлийн хүүг жилийн 8 найман болгов. Хэт хатуу моргейжийн систем нь “Их Хямрал”-ын үед сүйрч 1928 онд байсан 5778 моргейжийн зээл нь таван жилийн дотор буюу 1933 онд 864 болтлоо буурчээ. Тухайн үед олгогдсон олон олон моргейжийн зээл нь ямар ч үнэ цэнэгүй болж эхлэсэн.

Энэ үед ерөнхийлөгч Franklin D.Roosevelt орон сууц эзэмшигчдэд зориулж тэдний үл хөдлөх хөрөнгийг хамгаалах зорилгоор “Орон сууцны зээлийн корпораци”-ийг байгуулж, зээлийн нөхцөлийг харьцангуй уян хатан болгож, хүүг таван хувь, хугацааг 25 жил гэж өөрчилсөн байна. “Орон сууцны зээлийн корпораци” нь газар авч шинэ байр худалдан авагчдын бараг 40 хувь нь уг зээлд хамрагдах сонирхолтой болж эхлэв. Өргөдлөө өгсөн хүн болгон уг зээлд сонгогдох боломжгүй байсан тул 1934 онд Franklin D.Roosevelt нь Federal Housing Administration /ФНА/-ийг байгуулсан. Шинээр байгуулагдсан ФНА-ийн зээлийг Засгийн газар нь батлан даахаар тохиролцжээ. ФНА нь зээлэгчдэдээ орон сууцны зээлийг төлөх хугацааг нь 35 жил болгож сунгасан нь нэн тааламжтай болж ирэв. ФНА нь 1938 онд “Үндэсний Моргейжийн Холбоо” нэртэйгээр өргөжиж орон сууц худалдан авагчдад зориулж илүү хямд эх үүсвэрийг олох болов. Уг холбоо нь санхүүгийн зах зээл дээр баталгаажсан үнэт цаас арилжаалж мөн түүнчлэн зээлдэгчдэд зориулж мөрдөх ёстой хуулийг гаргав. Дэлхийн хоёрдугаар дайн гарснаар Моргейжийн зээлийн нөхцлийг дахин өөрчлөх болов. 1944 онд Конгрес G.I.Bill-ийг баталснаар илүү бага хүүтэй, урьдчилгаа төлбөргүй орон сууцны зээлийг бий болгов. Энэ зээл гарч ирснээр анх удаа үл хөдлөх хөрөнгө худалдан авагчид болон хөдөөнөөс хот руу шилжин ирэгсдийн тоо өсч эхэлсэн. Энэ нь моргейжийн зээлийн эрэлтийг өсгөх томоохон хүчин зүйл болсон түүхтэй.

2. Ипотекийн зээлийн онцлог

Ипотекийн зээл нь зээлдэгчийг нарийн төлөвлөж гаргаж ирсэн зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлбөрийг тогтмол хийдэг онцлогтой. Хэрвээ заасан хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд зээлдүүлэгч нь барьцаа хөрөнгө болох орон сууцыг зээл олгосон байгууллага хурааж авах бүрэн эрхтэй. Бусад төрлийн зээлээс ялгаатай нь нэг хүний бус гэр бүлийн зээл байдаг тул харьцангуй эрсдэл багатай гэж үздэг. Гэхдээ сар бүр төлөх зээлийн төлбөрийн хэмжээ нь зээлийн хэмжээ, хугацаа, хүү, нөхцөл зэргээс шалтгаална. Зээлийн хугацаа нь 10-30 жил байх ба хүү нь тогтмол, хувьсах гэсэн төрөлтэй байдаг.

Ипотекийн зээлийн давуу талууд:

- ❖ Зээл хүсэгчийн эрэлт хэрэгцээнд тохирсон орон сууцны зээлийн бүтээгдэхүүний өргөн сонголттой.
- ❖ Банкны орон сууцны зээлээр дамжуулан шинэ, хуучин аль ч төрлийн орон сууцыг худалдан авах боломжтой.
- ❖ Хувьсах хүү нь банкны эх үүсвэрийн хүү, улмаар макро эдийн засгийн нөхцөл байдлыг дагаж өөрчлөгддөг тул банк болоод харилцагчийг аль алийг нь ирээдүйд зах зээлийн өөрчлөлтөөс үүдэн учирч болох эрсдэлээс хамгаална.
- ❖ Зээлийн хугацаа харьцангуй урт байдаг.

Аливаа улс орны эдийн засгийн нөхцөл байдлыг орон сууцны үнийн өсөлтөөс харж болно. Хэрэв орон сууцны үнэ буурвал тухайн хөрөнгийг эзэмшиж буй хэрэглэгчдийн хувд хөрөнгийн үнэ цэнэ буурч байна гэсэн үг. Энэ нь иргэдийн улс орныхоо эдийн засагт итгэх итгэлийг бууруулна. Үл хөдлөх хөрөнгийн хоёрдогч зах зээлийг байгуулснаар баталгаажсан үнэт цаас бий болж мөнгөний урсгалыг дэмжинэ. Ипотекийн зээл авснаар эдийн засагт тогтмол орлоготой, ажилтай иргэдийн тоо өснө. Ипотекийн зээл авсан иргэд нь гэр орноо тохижуулах зорилгоор гэр ахуйн цахилгаан бараа зэргийг худалдан авдаг. Энэ нь эргээд жижиг дунд бизнесийг дэмжих нэг хүчин зүйл болдог.




3. Монголын ипотекийн зах зээлийн өнөөгийн байдал

Ипотекийн нийт зээлийн үлдэгдэл 873.7 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 12.2 хувийг эзэлж байна. Мөн энэ онд нийт зээлдэгчийн тоо 29946 хүрсэн байна. Зээлийн жигнэсэн дундаж хүү 16.8 хувь, жигнэсэн дундаж хугацаа 12.8 жил, Засгийн газрын хөтөлбөрийн зээлийн хүүгийн хэмжээнд оролцуулахгүйгээр жигнэсэн дундаж хүү 17.5 хувь байна. (Монгол банк, 2013.02 сар)Түүнчлэн Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх ипотекийн зээлийн хэмжээ 2003 онд өсөлтийн хувь 0.49 хувь байсан бол өнгөрсөн оны эцсийн байдлаар 6.04 хувь хүртэл өссөн байна. Ипотекийн зээлийн өрийн үлдэгдэл 2005 онд 30.840 сая төгрөг байсан бол энэ оны хоёрдугаарсарын байдлаар 897.3 тэрбумдтөгрөгт хүрсэн нь 29.1 дахин өсөлттэй үзүүлэлттэй байна.

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн хэмжээг нийт зээлд эзлэх хувь хэмжээгээр үзүүлбэл 2000 оноос хойш жил бүр өсөлттэй байгаа бөгөөд энэ оны эхний хоёр сарын байдлаар нийт зээлийн 12.2 хувийг эзэлж байна. Харин ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 2008 оны эхний байдлаар 0.33 хувь байсан бол мөн л 2010 оны эхний байдлаар 3.7 хувь хүрч цаашид аажмаар буурсан төдийгүй өнгөрсөн оны эцсийн байдлаар 0.59 хувь хүрсэн байна.

Зураг 1. Ипотекийн зээлийн нийт зээлд эзлэх хувь



Эх сурвалж: (Монгол банк)


Зураг 2. Нийт зээл болон ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь



Эх сурвалж: (Монголын Ипотекийн Корпораци) (Монгол банк)


Нийт зээлдэгчдийн хувьд тасралтгүй өссөн үзүүлэлттэй бөгөөд 2003 онд нийт зээлдэгчдийн тоо дөнгөж 1057 хүрч байсан бол энэ оны эхний байдлаар 29946 хүрсэн төдийгүй 2005-2007 онуудад огцом өсөлттэй гарсан байна. LTV (Зээл, барьцаа хөрөнгийн үнэлгээ) харьцаа нь Монгол Улсын хувьд 2011 оны IV улиралд хамгийн бага буюу 56 хувьд хүрч байсан нь зээлийн шалгуур болон зээл олголтын байдалтай шууд холбоотой тайлбарлагдах ба банкуудын хувьд LTV харьцаа дунджаар 65-70 хувь байна. 2005-2013 он хүртэлх дунджаар 70.81 хувь байна.

Зураг 3. Нийт зээлдэгчийн тоо



Эх сурвалж: (Монголын Ипотекийн Корпораци) (Монгол банк)

Зураг 4. LTV Анх олгосон байдлаар




Эх сурвалж: (Монголын Ипотекийн Корпораци)

Ийнхүү ипотекийн зээлийн хэмжээ, зээлдэгчийн тоо өсч буй шалтгаан нь иргэдийн тасралтгүй өсч буй эрэлт хэрэгцээнээс гадна төрийн бодлоготой салшгүй холбоотой юм. 2003 оныг хүртэл хязгаарлалттай олгогдож байсан ипотекийн зээл Азийн хөгжлийн банкны "Орон сууцжуулах хөтөлбөр"-ийн хүрээнд эхлэлээ тавьсан. Мөн арилжааны банкууд ч өөрийн санхүүжилтээр уг зээлийг олгох болсноор илүү олон хүн байртай болох нөхцөл бүрдсэн. Төрөөс 2004-2008 онд "40.000 айлын орон сууц"-ны хөтөлбөр хэрэгжүүлэн үл хөдлөх хөрөнгийн зах зээлд онцгой анхаарч эхэлсэн. Төрийн дэмжлэг, зээлийн эх үүсвэрээр байр худалдан авах иргэдийн тоо нэмэгдснээр 2005 оны 500 орчим ам.доллар байсан байрны үнэ хурдацтай өсч 1200 орчим ам.долларт хүрсэн билээ. Харин 2008 оны хагас жилээс банкуудын хадгаламжийн хэмжээ огцом буурч, гадаад валютын ханш чангарсан, инфляци, ажилгүйдэл нэмэгдсэн зэргээр дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямрал манай улсын эдийн засагт мэдрэгдэж эхэлсэн. Уг хямралын үед хамгийн их унасан салбар бол "Барилгын салбар" бөгөөд 2009 онд 34




хувиар бүүрсэн ба 2009 оны I улирлаас эхлэн чанаргүй зээлийн хэмжээ огцом нэмэгдэж 30 хувьд хүрсэн. Тиймээс барилгын салбарт олгогдох зээлийн хэмжээ 10 орчим хувиар бүүрсэн. Мөн банкууд орон сууцны зээлээ түр хугацаанд зогсоосноор байрны үнэ 15 орчим хувиар бүүрсэн.

Зураг 5. Шинэ орон сууцны үнэ ханш / ам.доллар/



Зураг 6. Барилгын салбарын чанаргүй зээл хувиар



Хямралын дараа буюу 2009 онд “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай”, 2010 онд “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай”, “Хөрөнгийн үнэлгээний тухай” хуулиуд батлагдаж эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрдсэн. Мөн 2010 онд “Төрийн албан хаагчийн 4.000 айлын орон сууц” хөтөлбөр, 2011 онд “100.000 айлын орон сууцны хөтөлбөр” батлагдаж “Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөр болж өргөжсөн. Үүнтэй зэрэгцэн арилжааны банкуудын хадгаламжийн хэмжээ нэмэгдэж, дахин орон сууцны зээл олгож эхэлснээр байрны үнэ эргээд өсч эхэлсэн. Эндээс байрны үнэ, зээл олголт шууд хамааралтай гэдгийг харж болно.

Үнэ гэдэг зах зээлийн зарчмаараа эрэлт, нийлүүлэлт дээр тогтодог зүйл бөгөөд эрэлт их байх нь үнийг өсгөдөг. Харин эрэлтийг өдөөх төрийн бодлого үнийн хэт өсөлт буюу “Хөөс” үүсгэдэг. Тухайлбал: “100.000 айлын орон сууцныхөтөлбөр”-ийг дэмжих зорилгоор 2012 оны хоёрдугаар сард жилийн зургаан хувийн хүүтэй орон сууцны зээл олгох шийдвэр гарсан. Тухайн үед банкуудын зээлийн хүү 17.5 хувь байсан ба бага зардлаар байртай болох сургаар зээлийн эрэлт нэмэгдэж, байрны үнэ дагаад 19 орчим хувиар өссөн. Харин энэ оны зургаадугаар сард батлагдсан “Орон сууцны ипотекийн санхүүжилт”-ийн журамд зааснаар 80 хүртэл м² орон сууцыг жилийн

найман хувийн хүүтэй зээлээр авах боломжийг олгосон. Харин журам батлагдсан долоо хоногт орон сууцны үнэ м² нь 200.000-300.000 төгрөгөөр ямар нэг шалтгаангүй нэмэгдлээ. Мөн энэ зээл нь ордер гарсан байранд олгогдох боломжтой тул шинэ байрнаас илүү хуучин байрны үнэ өсч байна.

4. Үнийн өсөлт ба Найман хувийн хүүтэй орон сууцны зээлийн төлбөр

Ипотекийн зээлийн төлбөрийг сар бүр тэнцүү хэмжээтэй төлөх ба хэмжээ, хүү, хугацаа зэргээс шалтгаалан сар бүр төлөх зээлийн төлбөрийн хэмжээ ялгаатай байна. Дараах хүснэгтэд 50.0 сая, 70.0 сая төгрөгийн зээлийг ипотекийн зээлийн дундаж хүү болох 16.8 хувь, хөнгөлттэй зээл болох найман хувийн хүүтэй гэсэн хоёр нөхцөлөөр 5, 10, 20 жилийн хугацаатайгаар зээлийн төлбөрийг тооцож харууллаа. Хэрэв 50.0 сая төгрөгийг таван жилийн хугацаатай авсан тохиолдолд сарын 1.237.258 төгрөгийг төлбөр төлөх бол найман хувийн хүүтэй зээл авснаар төлбөрийн хэмжээ 1.013.820 төгрөг буюу 223.438 төгрөгөөр буурч байна. Зээлийн хугацаа урт байх тусам сар бүр төлбөрийн зөрүү нэмэгдэж байна.

Хүснэгт 1. Зээлийн төлбөрийн тооцоо

Хугацаа	Зээлийн үндсэн төлбөр	
	50,000,000	70,000,000
	Зээлийн хүү 16.8%	
5 жил	(1,237,258)	(1,732,161)
10 жил	(862,662)	(1,207,727)
20 жил	(725,805)	(1,016,128)
Зээлийн хүү 8%		
5 жил	(1,013,820)	(1,419,348)
10 жил	(606,638)	(849,293)
20 жил	(418,220)	(585,508)
Зээлийн төлбөрийн зөрүү		
5 жил	(223,438)	(312,814)
10 жил	(256,024)	(358,434)
20 жил	(307,585)	(430,620)

Харин орон сууцны үнэ огцом нэмэгдэж байгаа нь зээлийн төлбөрийг хэмжээг бууруулж чадахгүй байна. Тухайлбал: 50.0 сая төгрөгийн байрны үнэ 70 сая болтлоо өссөн гэж үзье. Үнэ өсөөгүй 50.0 сая төгрөг байхад 16.8 хувийн хүүгээр таван жилийн хугацаатай зээл авахад сард 1.237.258 төгрөгийг төлж байсан бол харин одоо үнэ өсч 70.0 сая төгрөг болсны дараа найман хувийн хүүтэй зээл авснаар сард 1.419.348 төгрөг төлөх тооцоо гарч байна. Энэ нь бага хүүтэй хэдий ч байрны үнэ өсөх нь зээлдэгчидэд ашиггүй болохыг харуулж байна. (Хугацаа урт байх нь зөрүү бууруулах хэдий ч мөн л үнийн өсөлт зээлийн төлбөрийг нэмэгдүүлнэ)

Эндээс бага хүүтэй, өндөр үнэтэй орон сууц бус харин өндөр хүүтэй ч бага үнэтэй орон сууц хэрэгтэй




байгааг харуулж байна. Ялангуяа сүүлийн 100 гаруй жилийн хугацаанд гарсан дэлхийн томоохон санхүүгийн хямрал үүсгэсэн нэг үндсэн шалтгаан нь “Орон сууцны үнийн хөөс” юм.

5. Орон сууцны үнийн хөөс

Орон сууц нь анхдагч хэрэгцээнүүдийн нэг тул хүмүүс хэрэглээний зориулалтаар худалдан авахаас гадна илүүдэл нөөцөө байршуулах, өсгөх зорилгоор ашигладаг хөрөнгө оруулалтын нэг хэлбэр. Хөрөнгө оруулалтын зорилгоор худалдаж авах сонголт нь орон сууцны үнийн өсөлтөөс хамаарах ба энэхүү үнэ нь цаашид өссөөр байна гэсэн хүмүүсийн хүлээлттэй холбоотой. “Үнэ өснө” гэсэн хүлээлт нь зах зээл дээрх орон сууцны хэрэглээний эрэлтийг хөрөнгө оруулалтын эрэлтээр нэмэгдүүлснээр нийт эрэлт нь орон сууц үйлдвэрлэлийн хэмжээнээс давж үнийн өсөлтийг даамжруулдаг ба өөрөөр хэлбэл, үнэ өснө гэсэн хүлээлт нь өрсөлдөн худалдаж авах байдлыг үүсгэн зах зээлийн тэнцвэрийг алдагдуулж хуулиас гадуур үнийн бодит бус өсөлт буюу хөөс (Bubble) үүсгэдэг. Тодорхой цэгт хүрээд бодит бус өсөлт буюу хөөс хагарна нь зайлшгүй бөгөөд тэр үед хүмүүсийн хүлээлт эсрэгээр өөрчлөгддөг. Хөрөнгө оруулагчид орон сууцны үнийн уналтыг цаашид үргэлжилнэ гэж тооцоолж худалдаж авсан орон сууцаа аль болох түргэн борлуулахыг эрмэлзсэнээр зах зээл дэх худалдах орон сууцны тоо огцом нэмэгдэж үнэ цаашид буурдаг. Нөгөө талаас, иргэд орон сууц худалдаж авах шийдвэрээ хойшлуулснаар эрэлт огцом буурч орон сууцны зах зээл гацаанд орж, энэ нь нийт банк, санхүүгийн системд сөргөөр нөлөөлж, улмаар эдийн засгийн хямралд орох аюултай.

Зураг 7. Орон сууцны үнийн хөөс ба түүний үр нөлөө



Эх сурвалж: Asset price bubble, 2005

Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн хөөс үүссэн олон жишээ байдаг. Үүнд:

- Япон улс дахь үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн хөөс (1986-1991 он)
- АНУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн хөөс (1995-1998 он)
- Английн үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн хөөс (1997-2006 он)
- Австрали улсын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн хөөс (1995-2008 он)
- АНУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн хөөс (1999-2006 он)
- Ирланд улсын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн хөөс (1999-2006 он)
- Хятад улсын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн хөөс (2005-2013 он) зэргийг нэрлэж болно.

Эдгээр улсад нь орон сууцны зээлийг дэмжих хөрөлбөрийг хэрэгжүүлснээр үл хөдлөх хөрөнгийн үнэ огцом өссөн. Орон сууцны хүн амын анхан шатны хэрэгцээ байдаг ба аль ч улсын, аль ч төрийн үед мөрийн хөтөлбөртөө тусгадаг гол зүйл нь орон сууцжуулах байдаг. Үүнийг хэрэгжүүлэх шилдэг арга нь “Ипотекийн зээл” ба уг зээлийн хүүг бууруулах, хугацааг уртасгах, урьдчилгаа төлбөрийг бууруулах, төрөөс баталгаа гаргах зэрэг бүхий л талаас нь уг зээлийн хүрээмжийг нэмэгдүүлдэг. Харин эдийн засагтаа үзүүлэх гол сөрөг тал нь үнийн өсөлт байдаг. Орон сууцны үнийг төрөөс шууд бууруулах боломжгүй тул шууд бус аргаар бууруулахын тулд төсвөөс багагүй зардал гаргадаг. Үүнээс гадна хамгийн хүнд ачааг бизнес эрхлэгчид, зээл авсан иргэд үүрэх болдог.

Харин гадны зарим улсад орон сууцны үнийг тогтворжуулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. (Зураг 8)

Зураг 8. Бодлого зохицуулалт:

Энэтхэг улс	<ul style="list-style-type: none"> • Орон сууцны зээлийн хэмжээнд хязгаарлалт тавьсан • Үл хөдлөх хөрөнгийн эрдэлээр жигнэсэн хувийг нэмэгдүүдсэн
Хонг конг улс	<ul style="list-style-type: none"> • Үл хөдлөх хөрөнгийн худалдаанд анхаарлаа хандуулж иргэд болон аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгийн худалдан авалтад хязгаарлалт тавьж эхэлсэн. • Тансаг буюу өндөр зэрэглэлийн сууцны ипотекийн зээлийн хязгаарлалтыг хийсэн.
Хятад улс	<ul style="list-style-type: none"> • Орон сууцны дамлан наймаатай тэмцэх зорилгоор нэгдсэн нөгөөд шилжүүлэхэд ХАОАТ ноогдуулсан • Худалдан авсан орон сууцаа таван жилийн дотор борлуулах тохиолдолд өндөр хэмжээний татвар ноогдуулах • Урьдчилгаа төлбөрийн хэмжээг нэмэгдүүдсэн ба энэ нь эрдэлийг бууруулж байгаа нэг хэлбэр юм.

Эх сурвалж: (Claudio Aioly, 2011)



Өмнөх туршлагаас харахад орон сууцны үнийн хөөс нь санхүүгийн системд хямрал авчрах үндсэн шалтгаан болдог байна. Тиймээс төрийн зүгээс орон сууцны үнийг тогтворжуулах дорвитой арга хэмжээг авах шаардлагатай байна. Монголбанк, БХБЯ-ны хамтарсан “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг энэ оны эхэнд боловсруулан ажиллаж байгаа ч одоогийн энэ үнийн өсөлтийг сааруулж чадахгүй байна.

Найман хувийн хүүтэй зээл зээлдэгчдэд давуу талыг бий болгох зүйл хэдий ч нийлүүлэлт хязгаарлагдмал байгаа өнөө үед арай эртэдсэн хэрэг болжээ. Ирэх 2016 онд V цахилгаан станцыг ашиглалтад орохоос нааш Улаанбаатар хотод шинээр баригдаж буй орон сууцуудад цахилгаан, дулаан өгөх ямар ч боломж байхгүй талаар энэ оны эхээр хотын дарга мэдэгдэж байсан. Одоо зөвшөөрлөө авсан цөөн байр л дулаанаа авах боломжтой төдийгүй цаашид дэд бүтцийн асуудлаас шалтгаалан шинээр орон сууц ашиглалтад орох боломжгүй болж, нийлүүлэлт хязгаарлагдмал хэвээр байх төлөвтэй. Үнийн хэт өсөлтийг бууруулах төрийн бодлого үгүйлэгдэж байна.



ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ГАРАА БА БАРИА

Сэтгүүлч: Б.Алтай

Төв банкны Үнэ тогтворжуулах хөтөлбөр нэг сумаар хоёр туулай буудлаа. Засгийн газар, Монголбанкны хамтран хэрэгжүүлж буй тус хөтөлбөрийн хүрээнд барилгын салбар сэргэж, ипотекийн зээл хэрэгжих үндсэн нөхцөл бүрдсэн гэж хэлж болно. Тухайлбал, “Барилгын салбарыг дэмжих улмаар орон сууцжуулах” дэд хөтөлбөр зөвхөн үнийн дарамтыг чөлөөлөөд зогсохгүй зах зээлд шинэ боломж олгов. Инфляци аажмаар уруудаж, бодлогын хүү бууж, банкны зээл олголт эрчимжиж, эдийн засагт эерэг үзүүлэлтүүд бий болов. “Зах зээлээс бараг л гурав дахин бага хүүг ипотекийн зээл санал болгосон” хэмээн Эдийн засгийн бодлогын хүрээлэнгийн захирал А.Жаргалсайхан онцлов. Үүнээс гадна өрхийн сарын орлого нэг сая төгрөгт хүрч байвал ипотекийн зээлд хамрагдах магадлал илүү өндөр. Мөн худалдан авч буй байрныхаа нийт үнийн дүнгийн 30 хувь нь бэлэн бол ипотекийн зээл таных боллоо гэсэн үг. Ажилтай, орлоготой хэн бүхний өмнө нээлттэй тус хөтөлбөр 990 тэрбум төгрөгийн санхүүжилттэй.

Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр хэрэгжсэн эхний 34

хоногт зээлийн санхүүжилт хүссэн өргөдөл арилжааны банкуудыг дарсаар. Үүнээс банкууд 14598 иргэний хүсэлтийг бүрэн шийдвэрлэж, орон сууцны ипотекийн 421.1 тэрбум төгрөгийн зээлийг дахин санхүүжүүлж, зээлийн хүүг найман хувьд шилжүүлжээ. Иргэд 265.2 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээл шинээр авах хүсэлт гаргаснаас 3658 иргэнд 194.1 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээл шинээр олгоод байна.

Орон сууцжуулах хөтөлбөрийг урт хугацаанд амжилттай хэрэгжүүлэх нь үндэсний мөрөөдөл. Тус хөтөлбөр хэр амжилттай хэрэгжих эсэх нь Төвбанкнаас бус Засгийн газраас хамаарах учиртай. Өөрөөр хэлбэл, ипотекийг мөнгөжүүлэх нь дундаж давхаргаа дэмжиж буй хэрэг. Засгийн газрын мөрийн хөтөлбөр чинээлэг дундаж давхаргыг бий болгох гэсэн заалт ч бий. Тиймээс гарааны зурхайгаас эргээд буй орон сууцжуулах хөтөлбөрийг дунд хугацаандаа “авч үлдэх” нь Засгийн газрын сорилт, Монголбанкны хүсэл болоод байна. Хөтөлбөр найдвартай хэрэгжих нь макро эдийн засгийн тогтвортой байдалд эерэг нөлөөтэйг эдийн засагчид онцолж буй.

Орон сууцжуулах хөтөлбөрт шаардлагатай эхний ээлжийн хөрөнгийг Төвбанкнаас шилжүүлсэн. Цаашид Засгийн газар орон сууцжуулах хөтөлбөрийг мөнгөжүүлэх, ипотекийн хоёр дахь зах зээлийг хөгжүүлэхэд томоохон үүрэгтэй оролцох шаардлага үүсээд буй. Энэ оны төсөвт дээрх хөтөлбөртэй холбоотой ямар ч санхүүжилтийн эх үүсвэр суугагүй. Урьдчилгаа 30 хувийн босготой, 20 хүртэлх жилийн хугацаатай ипотекийн зээл иргэдийн



амьдралд туйлаас хэрэгтэй. Тэгж гэмээнэ “Утаатай” Улаанбаатар “Азийн цагаан дагина” гэсэн алтан титэм хүртэх учиртай.

Монголын Ипотекийн Корпорац /МИК/-ийн гүйцэтгэх захирал Ц.Энхбаяр “Манай улсад ипотекийн анхдагч зах зээл буюу урт хугацаатай орон сууцны санхүүжилтийн зээл 2003 оноос бий болсон гэж үздэг. Түүнээс хойш амьдарч байгаа орон сууц барьцаалаад зээл авсан зээлдэгчдийн тоо өнөөдрийн байдлаар 30 мянгад хүрсэн бөгөөд 870 тэрбум орчим төгрөгийн зээл зах зээлд байна” гэв. Хамтарсан хөтөлбөрийн дүнд дээрх 870 тэрбум төгрөг 10 их наядад хүрэх боломжтой аж. Хэрэв нийт зээлийн хэмжээ таван их наяд төгрөгт хүрсэн тохиолдолд өөрийгөө санхүүжүүлэх бүрэн боломжтой хэмээн Монголбанкны ерөнхийлөгч тэмдэглэсэн. Гэхдээ эрхзүйн болоод эдийн засгийн багагүй шинэчлэл, цаг хугацаа шаардлагатай болохыг өгүүлсэн.

Ипотекийн зээл нь Монголд шинэ тогтолцоо. Тиймээс ипотекийн зээлийг үнэт цаасжуулах замаар зээлийн эх үүсвэрийг дахин бий болгох талаар холбогдох албаны хүмүүс хэлэлцээд байгаа. Монголбанкны ерөнхий эдийн засагч С.Болд “Монголын ипотекийн корпораци мөнгөгүй. Монгол Улсын нийгмийн даатгалын сан хасах баланстай. Засгийн газарт ч бас эх үүсвэр хомс байна. Энэ нөхцөлд Төвбанк л эх үүсвэрийг гаргана” хэмээн өгүүлсэн. Түүний хэлснээр Монголбанкнаас эхлэлийн санхүүжилтээр гаргасан мөнгө ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас болох бөгөөд Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийн хүрээнд нийгмийн даатгалын санг дахин хөрөнгөжүүлэх ёстой аж. Ингэснээр Засгийн газар дотоодын зах зээл дээр бонд гаргаж, нийгмийн даатгалын сангаа мөнгөжүүлсэн тохиолдолд Монголбанк ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасаа нийгмийн даатгалын санд байршуулаад, төгрөгөө өөр дээрээ татах нөхцөл бүрдэх юм байна. Цаашдаа банк ч гэсэн өөрийн гэсэн хувийн хэвшилд тулгуурласан ипотекийн зээлийг санхүүжүүлэх эх үүсвэртэй болж, эх үүсвэр нь нэмэгдээд явах аж. МИК ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасаа гаргах замаар мөнгөжих бол нөгөө талдаа Нийгмийн даатгалын сан хөрөнгөжих нь. Дээрх эргэлтийн дүнд ипотекийн зээл урт хугацаандаа тогтвортой орших юм.

Дундаж давхаргыг мөргөйж буюу ипотекийн түвшингээр судлахад ДНБ-д эзлэх ипотекийн зээлийн хувь Германд 45, Японд 40, Сингапурт 36, БНСУ-д 13 хувь байдаг аж. Харин манай улсын хувьд ДНБ-д эзлэх хувь нь ердөө зургаан хувьтай тэнцэж байна. Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын 66 хувь буюу 316 мянган өрх айл гэр хороололд амьдарч байна. Орон сууцжуулах хөтөлбөрийн чин хүсэл нь дээрх харьцааг ойртуулах, гэр хорооллыг орон сууцжуулах ажлыг түргэсгэх явдал.

Өнөөдрийн байдлаар манай улсад ДНБ-ий 6.2 хувьтай тэнцэх хэмжээний ипотекийн зээл байгаа аж. Энэхүү хэмжээ нь тун бага үзүүлэлт болохыг албаны хүн тайлбарласан юм. Учир нь дэлхийн ихэнх орнуудад ипотекийн зээл ДНБ-ий 40 – өөс доошгүй хувийг эзэлдэг байна. Ингэснээр инфляци жилийн 1-2 хувийн өсөлттэй буюу тогтвортой байдаг аж. Ипотекийн зээл нь орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх, Засгийн газрын үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, зах зээлийн зарчимд суурилсан төрийн зохистой оролцоог бий болгох. Мөн ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх, орон сууцны санхүүжилтийн тогтвортой, урт хугацааны тогтолцоог бэхжүүлэх давуу талтай аж.

Олон улсад орон сууцны үнийг иргэдийн орлоготой харьцуулахад нэг хүний жилийн дундаж орлогыг дөрөв дахин нугалсантай тэнцүү бол хэвийн гэж үздэг байна. Тэгвэл манайд өнгөрсөн оны байдлаар улсын хэмжээний дундаж орлого 545 мянган төгрөг, дундаж хоёр өрөө байрны үнэ 75-80 сая төгрөг гэж үзвэл энэ харьцаа 11 болж орон сууцны үнэ маш өндөр үнэтэйд орохоор байна. Хэрэв өрхийн бодит орлогыг нэг сая төгрөг гэж үзвэл тус харьцаа зургаа болон буурах аж.

Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал “Ипотекийн зээл хамгийн сайн зээлийн тоонд багтдаг. Тиймээс нэг бус 4-5 их наяд төгрөгт хүргэхийн төлөө бид зорьж байгаа” гэв. Ипотекийн зээлийн чанар сайн байдаг тул арилжааны банкууд энэ чиглэлийн зээл олгох сонирхол ихтэй байгаа аж. Тус зээлийн багцад чанаргүй зээл байхгүй бөгөөд хугацаа хэтэрсэн зээл дөнгөж 0.3 хувийг эзэлж байна. Нэг үгээр хэлбэл, чанартай бүтээгдэхүүн гэж дүгнэж болно. Гараа сайн бол бариа сайн гэдэг. Тиймээс асаасан галаа бөхөөхгүйн тулд ипотекийн зээлийг Засгийн газар шат дараатай санхүүжүүлэх учиртай.





МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБООНООС 2013 ОНЫ III УЛИРАЛД ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БАЙГАА СУРГАЛТ СЕМИНАР

Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо 2013 онд зохион байгуулах сургалтын хуваарь гаргаж салбарын удирдлага болон инженер техникийн ажилчдын мэдлэг, боловсрол, үр чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах, туршлага судлуулах үүднээс холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран орчин үеийн тоног төхөөрөмж дээр онол практик хослуулан дотооддоо 16 удаагийн сургалтад 206 ажилтан сургаад байна.

Мөн гадаад орны тэргүүн туршлага, шинэ техник технологитой танилцах, туршлага судлах, Олон улсын үзэсгэлэнд хамрагдах төлөвлөгөөний дагуу 4 улсад 33 хүн хамруулан туршлага судлан, суралцаад байна.

1. МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБОО-с 2013 оны 05 дугаар сарын 06-10-ны хооронд 5 хоног “ДУЛААНЫ ГОРИМ ТОХИРУУЛГЫН ИНЖЕНЕРИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ” чадавхижуулах 36 цагийн сургалт зохион байгууллаа. Тус сургалтанд сүүлийн үеийн шинэ техник технологитой танилцаж, орчин үеийн тоног төхөөрөмж дээр онол практик хослуулж сургасан бөгөөд, Улаанбаатар Дулааны сүлжээ ХХК-ийн мэргэжлийн зөвлөх инженерүүд хичээл зааж хот, хөдөө орон нутгийн 10 инженер техникийн ажилчид хамрагдлаа. Сургалтад суралцагчид сэтгэл ханамж өндөртэй байлаа.



2. “МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБОО”, УСУГ-н “СУРГАЛТЫН ТӨВ”-тэй хамтран НАА-н салбарт мэргэжилтэй ажилтан бэлтгэх зорилгоор “Цэвэр, бохир усны машинистын мэргэжил олгох” сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад хот, хөдөө орон нутгийн 8 ажилтан хамрагдсан мэргэжилтэй боллоо.



3. 2013 оны 01 дүгээр сараас эхлэн Улаанбаатар хотын Хувийн хэвшлийн орон сууцны компанийн захирлуудад Удирдлагын академитай хамтран “Компанийн засаглал” цуврал семинар, сургалтыг сард нэг удаа буюу 5 удаа зохион байгууллаа.





МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБООНООС ЗОХИОН БАЙГУУЛЖ ШАНХАЙ ХОТОД “AQUATECH CHINA-2013” ОЛОН УЛСЫН УСНЫ ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦООД ИРЛЭЭ

Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооны гишүүн байгууллагын инженер техникийн ажилчдын мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх, тэргүүн туршлага, шинэ техник технологитой танилцах, туршлага судлах үүднээс БНХАУ-ын Шанхай хотод “Aquatech China-2013” олон улсын усны үзэсгэлэн энэ оны 6 дугаар сарын 05-наас 11-ний өдрүүдэд 9 хүн хамруулан туршлага судлан, суралцаад ирлээ.

Үзэсгэлэнд МНААУХолбооны гишүүн байгууллагуудаас Ховд аймгийн “Шим ус” ХХК, Баян-Өлгий аймгийн “СУАТ” ХХК, Дорноговь аймгийн “Чандмань Илч” ХХК, Хөвсгөл аймгийн “Хөвсгөл Дулаан” ХХК-ууд өөрийн инженер техникийн ажилтан, ажиллагсад оролцлоо.

ОУҮзэсгэлэнгийн гол зорилго нь Нийтийн аж ахуйн системд тулгамдаж буй асуудлыг цогцоор нь харуулсан байлаа. Нийтийн аж ахуйн системд ашиглагдаж буй инженерийн шугам сүлжээний ашиглалтыг сайжруулах, уртасгах, газар доорх шугам сүлжээг шинэчлэх шинэ техник технологитой танилцаад ирлээ.

Бид мөн үзэсгэлэнгээ сонирхохоос гадна, чөлөө цагаараа Бээжин болон Шанхай хотоор аялан, сэтгэгдэл өндөр сайхан явж ирлээ.





ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОНЦЛОГ

Нэг ангийнхан



МНААҮХолбооноос зохион байгуулж Оросын холбооны улсын Новосибирск хотын Барилга архитектурын их сургууль дээр 2013 оны 5-р сарын 13-24 ны хооронд Орон сууц нийтийн аж ахуйн салбарын инженерүүдийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд нийт 12 хүн оролцсон. Нийт 120 цагийн кредитийн хичээл үзэж мэргэшүүлэх сургалтын сертификат авлаа. Сургалтын хүрээнд инженерийн шугам сүлжээний онцлог, ашиглалтын шаарлага техник үзүүлэлтүүд,

ашиглалтын үеийн ус дулааны ачаалал гидравлик тооцоо, сүүлийн үеийн дэвшилтэд техник технологийн талаар туршлага судласан. Сургалтын программын дагуу усны эх үүсвэр, ус сувгийн удирдах газар, хамгийн сүүлийн үеийн автоматжсан өргөлтийн насосны станц, төв диспетчерийн алба, ус дулаан дамжуулах төв мөн орон сууцны үйлчилгээний компаний үйл ажиллагаатай танилцлаа.

Танилцах аялалаар



Дулааны өргөлтийн насос станц болон механик удирдлага хяналтын самбар




Дулааны өргөлтийн насосны автомат Удирдлага хяналтын самбар



ХҮЙТЭН УС БОЛОН АРИУТГАХ ТАУУРГЫН ӨРГӨЛТИЙН НАСОС СТАНЦЫН БАЙРШИЛ

Уг удирдлагын самбар нь олон давуу талтай:


- ❖ Энэхүү схем дээр хүйтэн ус болон ариутгах татуургын өргөлтийн насос станцын ажиллаж байгаа эсэх шугамын дүүргэлтийн хэмжээ зэргийг өнгөөр ялган харагдаж байдаг.
- ❖ Уг удирдлагын самбар дээр ашиглалтын өгөгдлүүдийг бүртгэж харах боломжтой. Мөн засвар үйлчилгээг илүү оновчтой болгох зорилгоор буруу ажиллагаа, буруу заалтыг бүртгэх боломжтой.
- ❖ Солих хугацааг нь тодорхойлох зорилгоор үндсэн тоноглолуудын ашиглалтын хугацааг бүртгэх боломжтой.





ХЯНАЛТ УДИРДЛАГЫН ХЭСЭГ

Энэ программ нь параметрын мэдээг хянаж хадгалдаг. Мөн шугам сүлжээн дээр гарсан эвдрэл гэмтэл засвар үйлчилгээг Наряд хэлбэрээр хадгалж архивладаг. Мөн гарсан эвдрэл гэмтэл холбогдох хүмүүст утсанд нь мессежээр мэдэгддэг.



Усны алдагдал болон шугамын трасс илрүүлдэг орчин үеийн багажууд

Эдгээр багажууд нь шугамын усны зарцуулалт, трасс, усны алдагдлыг илрүүлдэг, мөн шугамын элэгдэл буюу зузааныг хэмждэг багажуудыг хэрэглэдэг бөгөөд Эдгээр багажуудыг хэрэглэсний дүнд усны алдагдлыг 35хувиас 12 хувь хүртэл бууруулж чадсан байна.



Ариутгах татуургын шугамын угаалгын машин тоноглол



ЭРХҮҮ ХОТЫН ОРОН СУУЦНЫ УДИРДАХ ГАЗАРТАЙ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ.

Оросын холбооны улсын орон сууцны үйлчилгээний байгууллагуудын онцлог нь 2007 онд батлагдсан орон сууцны хуулийн дагуу эх үүсвэрийн байгууллага нь хэрэглэгч хүртэлх үйлчилгээгээ хариуцдаг бөгөөд эх үүсвэрээс хэрэглэгч хүртэл нэг тарифаар авдаг байна. Инженерийн шугам сүлжээний засвар үйлчилгээг эх үүсвэрийн байгууллага хариуцдаг ба засаг захиргааны төсвөөс санхүүждэг. Орон сууц ашиглалтын байгууллага нь районы хэмжээнд 100-150 байр хариуцдаг ба байрны дотор инженерийн шугам сүлжээ, дулааны зангилаа, магистрал шугамыг хариуцаж ажилладаг нь манайхаас ялгаатай байна. Байрны оруулга бүр дээр ус дулааны тоолууртай бөгөөд хэрэглэсэн ус дулааны зөрүүг хэрэглэгчид хувааж төлнө. Байрны засвар үйлчилгээний хуримтлалыг орон сууцны ашиглалтын компани хариуцдаг ба жижиг засвар үйлчилгээ, цэвэрлэгээг хувь компаниудтай гэрээлж хийлгэдэг байна.

ОХУ ын Томск хотын барилга архитектурын их сургуулийн 2013-2014 оны хичээлийн жилд 25 төрлийн мэргэжлээр элсэлт авч байна. Манай хоёр байгууллагын хооронд байгуулсан гэрээний дагуу тус сургуулийн барилгын факультетийн ус хангамж, дулаан хангамжийн мэргэжлээр тогтвор сууришилтай ажилладаг, орос хэлний тодорхой мэдлэгтэй инженер техникийн ажилчдаас магистрийн сургалтанд ОСНААУГ-аар зардлаар суралцах боломжийг олгож байна.

Мэдээлэл тавьсан ОСНААУГ-н дотоод хяналтын ажилтан н.Цэрэннадмид



ТӨВИЙН БҮСИЙН НААУ-НИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН СПОРТ УРЛАГИЙН ТЭМЦЭЭН ШАРЫН ГОЛЫН УУРХАЙН АМРАЛТАД АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ

Төвийн бүсийн НААУ-ний байгууллагуудын хамт олны ажлын үялдаа холбоо бэхжүүлж сайжруулах, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, хөдөлгөөний хомсдлоос сэргийлэх, ажилчдын идэвхи санаачлагыг дээшлүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилготойгоор жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг урлаг спортын тэмцээн 2013 оны 6-р сарын 27-30-ны өдрүүдэд “Дулаан Шарын гол” ТӨХК зохион байгууллаа.



Тэмцээнд Барилгын хөгжлийн төв, Улаанбаатар Ус сувгийн удирдах газар, Хөтөл “Гавшгай-ус” ХХК, Төв аймаг “Төв чандмань” ДЭХГ, Дархан-Ус суваг ХК, Дулаан Шарын гол ТӨХК-н 6 багийн 150 гаруй тамирчид авьяас билиг оюун ухаанаа дайчлан Гар бөмбөг, Шатар, Теннис, Модон бөмбөг, Сур харваа, Урлагийн тоглолт



гэсэн 6 төрлөөр уралдлаа.

Үүнд багийн нийт оноогоор “Дулаан Шарын гол” ТӨХК 1 байр эзэлж, 2-р байранд “Улаанбаатар ус суваг” ХК орж, 3-р байранд “Дархан ус суваг” ХК тус тус эзэллээ. Энэхүү зохион тэмцээнд оролцсон баг тамирчид маш өндөр сэтгэгдэлтэй дараа жил үлзэхын



Байгууллагын дарга, ерөнхий нягтлан нарын дунд зохион байгуулсан Модон бөмбөг



Урлагийн тоглолтын аваргууд

Ширээний теннисийн аваргууд



Эрэгтэй шатрын аваргууд



Эмэгтэй аваргууд



“Дулаан Шарын гол” ТӨХК 1-р байр



Улаанбаатар “Ус сувгийн удирдах газар” 2-р байр



Дархан “Ус суваг” ХК 3-р байр



УЛААНБААТАР ХОТЫН ХУВИЙН ХЭВШЛИЙН ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН КОМПАНИУДЫН УЛАМЖЛАЛ БОЛГОН ЗОХИОН БАЙГУУЛДАГ САГСАН БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН БОЛЛОО

ХХОСНАА-н компаниудын хамт олны уламжлал болгон явагддаг биеийн тамирын олон төрөлт тэмцээний эхний хэсэг болох сагсан бөмбөгийн тэмцээнийг 2013 оны 5 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд **“Ганбиж” ХХКомпани** зохион байгууллаа.



Тэмцээнд 18 байгууллагын эрэгтэй 14 баг, эмэгтэй 10 багийн 200 гаруй тамирчид оролцов.



Тэмцээн маш сайхан үнэн шударга, өрсөлдөөнтэй болж өнгөрсөн бөгөөд эмэгтэй багийн нэгдүгээр байрыг “Бадамлах нар” ХХК-ийн Б.Монголжингоо ахлагчтай баг, хоёрдугаар байрыг “Ганбиж” ХХК-ийн М.Ичинхорлоо ахлагчтай баг, гуравдугаар байрыг “МОНТС” ХХК-ийн Д.Мягмарсүрэн ахлагчтай баг тус тус эзэлж, эрэгтэй нэгдүгээр байрыг “Богд-Асар” ХХК-ийн Г.Гантулга ахлагчтай баг, хоёрдугаар байрыг “Хайспид” ХХК-ийн У.Дөлгөөн ахлагчтай баг, гуравдугаар байрыг “Гантус” ХХК-ийн Л.Батболд ахлагчтай багууд тэргүүний байр эзэлж алт, мөнгө, хүрэл медалийн эзэд боллоо.

Тэмцээнд оролцсон тамирчдаас хурд, хүч, авьяас чадвараа “Ганбиж” ХХК-ийн ахмад тамирчин М.Ичинхорлоо, “Бадамлах нар” ХХК-ийн тамирчин Б.Лхагвасүрэн нар шалгарч тусгай шагнал хүртэв.

Ийнхүү ХХОСНАА-н компаниуд 2 өдөр авхаалж самбаа гарган биеийн тамир спортоор амьсгалж, алжаалаа тайлан иргэд суугчдынхаа сайн сайханы төлөө эрчимтэй үйлчлэх эрмэлзэл дүүрэн ажиллахаар тамирчдын марш дуулан өндөрлөлөө.

“Бадамлах нар” ХХК



МНААҮХ-ны мэргэжилтэн Б.Алтантуул



ЗҮҮН БҮСИЙН НААҮГ-ЫН БАЙГУУЛЛАГУУДЫН **VII НААДАМ** НАЛАЙХАД АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ

Зүүн бүсийн НААҮГ-ын байгууллагуудын 7-р наадмыг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг. Энэ удаагийн үйл ажиллагааг “Чандмань Налайх” НӨҮГазар төлөвлөгөө боловсруулж, комисс гарган ажиллаж, зохион байгууллаа. Үүнд 5-н аймгийн 5 баг, 85 тамирчид ирж авъяас билиг оюун ухаанаа дайчлан 6 төрлийн тэмцээнээр уралдаж багийн нийт оноогоор Багануур дүүрэг “Багануур ус” НӨҮГ 1 байр эзэлж, 2-р байранд “Чандмань Налайх” НӨҮГ орж, 3-р байранд Сүхбаатар аймгийн “Дөрвөлж” ХХК тус тус эзэлсэн. Энэхүү үйл ажиллагааг зохион байгуулахад Дүүргийн Засаг Дарга болон Тамгын Газар, ИТХ дарга, хамт олон дэмжсэн сайхан наадам боллоо.



Байгууллагуудыг хүлээн авч байгаа нь



“60 секунд ба 600 мянган төгрөг” тэмцээнд оролцож байгаа нь



Дүүргийн засаг даргын хамт



“Дардас шидэлт”-ийн тэмцээнд оролцож байгаа



“Мини футбол” болон “Завь”-ны уралдааны үеэр





Байгууллагууд мэндчилгээ дэвшүүлж, гарын бэлгээ солилцож байгаа нь



Байгалийн үзэсгэлэнт газруудаар хөтөч нарын хамт аялж байгаа нь



“АХА” танин мэдэхүйн цэнгээнт тэмцээний үеэр



“Хүндэтгэлийн зоог”-нд амьд хөгжмийн хамтлагтай үдшийг өнгөрүүлж байгаа нь



Шилжин явах тугийг Дорноговь аймгийн “Чандмань Илч” ХХК-д гардуулан өгч байгаа нь



Шагнал гардуулах ёслолын үеэр тамирчид зураг авахуулж байгаа нь

Энэ жилийн наадмын онцлог нь гаднаас тамирчид оруулахгүйгээр өөрсдийн нөөц бололцоогоороо бие биенээ таньж мэдэх, арга туршлагаа ярилцах мөн тулгамдаж буй бэрхшээлээ даван туулж буй талаар хэлэлцсэн сайхан наадам боллоо. Баг тамирчид өөрсдийн авхаалж самбааг сорьсон танин мэдэхүйн болон спортын тэмцээний төрлүүдэд маш идэвхитэй оролцож нийт 11.180.370 төгрөгийн төсөв зарцуулан үйл ажиллагааг зохион байгуулсан. Нийт байгууллага хамт олон маш өндөр сэтгэлтэйгээр буцаж дахин дараа жил уулзах ерөөл тавин мордоцгоолоо.

Мэдээлэл гаргасан ХН Менежер Ц.Бямбадулам



МОНГОЛ ОРНЫ ГАДАРГЫН УСНЫ НӨӨЦ, ТҮҮНИЙ АШИГЛААЛ

П.Бадамдорж /Усны үндэсний хороо/

МОНГОЛ ОРНЫ УСНЫ НӨӨЦ



Нийт усны нөөц: 608.29 km³, Үүнээс;
Гол мөрөн: 34.6 km³
Нуурууд: 500 km³
Мөсөн гол: 62.9 km³
Газрын доорх ус: 10.79 km³



Монгол орны гадаргын усны ашиглах боломжит нөөц 5 км³ буюу 5000 сая м³ юм. Энэ нь Монгол орны ашиглах боломжит нийт усны нөөцийн 82.4 орчим хувь нь болдог.


ГАДАРГЫН УСНЫ НӨӨЦ

Гадаргын усны нөөц нь нөхөн сэргэлт хурдан динамик нөөц юм.



ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦ


Газрын доорх усны нөөц нь нөхөн сэргэлт удаантай статик нөөц юм.






УСНЫ НӨӨЦИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХУВААРИЛАЛТ

Монгол орны цавар усны эх үүсвэрийн 70 хувь бүрэлдэх газар




- ❖ Гадаргын усны нөөцийн 70 хувь нь уул нуруудын өндөрлөг хэсэг буюу Монгол орны нутаг дэвсгэрийн 30 хувьд бүрэлдэнэ.
- ❖ Манай орны нутаг дэвсгэрийн 76.7 хувийг эзлэх хээр, говь, цөлийн бүсэд гадаргын ус бараг байхгүй юм.

УС ХЭРЭГЛЭЭ




“Усны шинэтгэл-21” хөтөлбөрийн зорилт, 2004 он



УС ХЭРЭГЛЭЭ-АШИГЛАЛТ

Ус ашиглагч, хэрэглэгч салбарууд	Ус хэрэглээ-ашиглалт, сая м3/жил (2010 он)
Хүн амын унд, ахуйн ус	55.1
Нийгмийн ба ахуйн үйлчилгээ	9.4
Аж үйлдвэр, барилга, барилгын материал үйлдвэрлэл	81
Хөдөө аж ахуй	175.6
Бусад	6
Нийт ус хэрэглээ	327.1



Ус хэрэглээ ойрын ирээдүйд ихээхэн нэмэгдэх төлөвтэй байгаа ба мэргэжлийн байгууллагын дүн мэдээгээр 2000 сая м3/жил буюу 2 км3/жил болохоор байна. Хэтийн төлөвөөр хүн амын өсөлт, үйлдвэржилт хотжилт зэргээс шалтгаалан Монгол орны нийслэл Улаанбаатар хот болон өмнөд говийн бүс нутагт ус хангамжийн хүндрэлтэй нөхцөл бий болохоор байна.

УС АШИГЛАЛТ





“УС” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРТ ТУСГАСАН БАЙДАЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 24

Төрийн ордон, Улаанбаатар хот

«Ус» үндэсний хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хүрээнд хэрэгжүүлэх «Ус» үндэсний хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. «Ус» үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг зохион байгуулж, холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.
3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн бэйнгийн хороо /Б.Батбаяр/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр


Дугаар 304

Улаанбаатар хот

«Ус» үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Улсын Их Хурлын 2010 оны 24 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. «Ус» үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.
2. «Ус» үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган улсын төсөв болон бусад аж үүсвэрээс санхүүжүүлэх арга хэмжээг Сангийн сайд С.Баярцогт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадмажүнай, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.
3. «Ус» үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг орон даяар зохион байгуулж, салбар дундын ажлын үйлдвэр ханган, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бөгөөд Усны үндэсний хорооны дарга Л.Гансүх, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хэмжигуун)-нд үүрэг болгосугай.
4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан «Хөтөлбөр батлах тухай» Засгийн газрын 1999 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 43 дугаар тогтоол, «Үйл ажиллагааны чиглэл батлах тухай» Засгийн газрын 2004 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 57 дугаар тогтоол, «Хөтөлбөр батлах тухай» Засгийн газрын 2006 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 246 дугаар тогтоол, «Хөтөлбөр батлах тухай» Засгийн газрын 2008 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 84 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болгохыг тооцсугай.



С.БАТБОЛД

Л.ГАНСҮХ

“УС” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Усны үндэсний хөтөлбөр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

УСНЫ ҮНДЭСНИЙ ХОРОО

УС

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот
2011 он

Хөтөлбөр хоёр үе шаттай хэрэгжих бөгөөд эхний буюу эрчимтэй хөгжлийн үе 2010-2015 онд, хоёр дахь буюу тогтвортой хөгжлийн үе 2016-2021 онд хэрэгжинэ.

“УС” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРТ ТУСГАСАН БАЙДАЛ

3.3. Усны нөөцийн хуримтлалыг бий болгох, хүн амыг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцсэн усаар хангаж, үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн ус хангамжийг сайжруулан тогтвортой хөгжлийг тэтгэх үндсэн нөхцөл бий болгох зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:



Эхний үе шатанд (2010-2015 он):

Усны нөөцийн хуримтлал бий болгож, ашиглах чиглэлээр:

3.3.1. Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн усны нөөцийг хуримтлуулах усан сан, усан цахилгаан станцыг Ховд гол, түүний цутгал голуудын сав, хойт мөсөн далайн ай сав болон мөстөл, мөсөн голын доод талд байгуулах замаар 70,000-80,000 сая шоо метр тогтонги усны нөөцийг өндөр уулын бүсэд бүрдүүлж, ашиглах зураг төслийг боловсруулах;

3.3.2. Орхон, Сэлэнгэ, Хэрлэн, Туул, Ховд, Булган, Халх, Онон, Эг, Хархираа, Түргэн, Шишхэд, Ерөө, Харса, Тамир, Богдын голууд дээр урсацын тохируулга хийх, усан сан байгуулах, шилжүүлэн ашиглах боломжийн талаар судалгааг хийж, боломжтой газруудад зураг төсөл зохиох, барьж байгуулах ажлуудыг эхлүүлэх;

“УС” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРТ УСНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАЛААР ТУСГАСАН БАЙДАЛ

Усны эрчим хүчийг ашиглах чиглэлээр:

3.3.19. Монгол орны гол, мөрний эрчим хүчний нөөц, сэргээгдэх эрчим хүчний хөгжлийн төлөвлөлт, эрчим хүчний хэрэглээний эрэлт, шаардлага, салбарын нэгдсэн бодлого, төлөвлөлтийг Тайшир, Дөргөний усан цахилгаан станцын сургамж, түршлага, ашиглалтын үеийн хүндрэлүүдтэй уялдуулан дахин сайжруулах арга хэмжээг авах;

3.3.20. Чаргайтын 58 МВт, Эрдэнэбүрэнгийн 65 МВт усан цахилгаан станцын техник, эдийн засгийн үндэслэлийг хянан үзэж, боломжтой тохиолдолд бусад усан цогцолборуудтай уялдуулж гүйцэтгэх;

“УС” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРТ УСНЫ НӨӨЦИЙН ХУРИМТЛАЛ БИЙ БОЛГОХ ТАЛААР ТУСГАСАН БАЙДАЛ

Хоёр дахь үе шатанд (2016-2021 он):

Усны нөөцийн хуримтлал бий болгож ашиглах чиглэлээр:

3.3.22. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулахад чиглэсэн усны нөөцийг хуримтлуулах усан сан, усан цахилгаан станцуудыг Ховд гол, түүний цутгал голуудын сав, Хойд мөсөн далайн ай сав болон мөстөл, мөсөн голын доод талд байгуулах замаар 70,000-80,000 сая шоо метр тогтонги усны нөөцийг өндөр уулын бүсэд бүрдүүлж ашиглах;

3.3.32. Сэлэнгэ мөрний 300 МВт, Эгийн голын 220 МВт, Орхон голын 100 МВт-ын усан цахилгаан станцын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх боломжийг судалж шийдвэрлэх.


“19.11 ТОДОРХОЙ НУТАГ ДЭВСГЭРИЙН УСНЫ НӨӨЦИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, УСНЫ НАЙДВАРТАЙ ХАНГАМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ ЗОРИЛГООР БАЙГАЛИЙН УСНЫ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ, ГОЛ, ГОРХИЙГ НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭГ САНХҮҮЖҮҮЛСЭН ИРГЭН,

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН НИЙТ ОРЛОГОД НОГДОХ АЛБАН ТАТВАРЫГ ТУХАЙН АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ХЭМЖЭЭГЭЭР ХӨНГӨЛНӨ”


Энэ хуулийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр баталсан Усны тухай хууль/Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН ГАДАРГЫН УС АШИГЛАХ ЕРӨНХИЙ КОНЦЕПЦИ



Монгол орны зүүн, төв, баруун хэсгийн болон хойд зүгийн голуудын урсацад тохируулга хийн ус хуримтлуулан говийн бүсэд шилжүүлэн ашиглах боломжтой ба Хэрлэн, Туул, Орхон голоос эхний ээлжинд ус дамжуулах илүү боломжтой. Туул голд тохируулга хийж усан сан байгуулан зөвхөн УБ хотын хэрэглээнд ашиглах шаардлагатай тул үлдсэн 2 хувилбарыг алсын зайд шилжүүлэн ашиглах нь оновчтой юм. Ирээдүйд шаардлагатай бол Хэрлэн голыг Онон голын усаар, Орхон голыг Сэлэнгэ мөрний усаар тэтгэж дамжуулан ашиглах ерөнхий концепц байгаа болно.







Орхон голын олон жилийн дундаж урсац 44,1 м³/сек буюу 1400 сая шоо метр, (газрын доорхи урсацын нөөцөө тооцвол 2200 сая шоо метр) үүнээс ашиглаж болох боломжит нөөц 180 сая шоо метр.

Төслийн нийт ус хэрэглээ 2.5 м³/с (42,0 сая шоо метр) буюу голын дундаж урсацын 3 %, зөвшөөрөгдсөн нөөцийн 23 %-тай тэнцэж байна.

Хэрлэн голын олон жилийн дундаж урсац усан сан байгуулах хөндлүүрт 25.4 м³/сек буюу жилд 801,0 сая шоо метр, үүнээс ашиглаж болох боломжит нөөц 240 сая шоо метр.

Төслийн нийт ус хэрэглээ 1800 л/сек (35,0 сая шоо метр) буюу голын дундаж урсацын 4,0%, зөвшөөрөгдсөн нөөцийн 23,0 %-тай тэнцэж байна.



Сайншандын ойролцоох газрын доорх усны нөөцийг (Бор хөөвөр, Долоодын говь) тогтоож байгаль орчин, экологид зохистой, тодорхой хэмжээгээр хэрэглэх бололцоотой хэдий боловч бидний урьдчилсан тооцоогоор Сайншандын нийт ус хэрэглээний 20-30%-ийг л газрын доорх уснаас хангах боломжтой юм.

Бор-Өндөр болон Сайншандын аж үйлдвэрийн цогцолборын нийт ус хэрэглээний 70-80% болох 0.5 м³/сек (500 л/сек буюу 43,200 м³/хон) усыг голын хөндийн сэвсгэр хурдасд орших усыг газар доорх далан, хэвтээ ус татамжийн байгууламжаар хуримтлуулан авах бололцоотой гэж үзэж байна. Төслийн хүрээнд авах ба 500 л/сек-ийн зарцуулга бүхий усны 400 л/сек усыг Сайншандын аж үйлдвэрийн цогцолборт, үлдэх 100 л/сек-ийг Сайншанд, Бор-Өндөр болон зам дагуух Баянмөнх, Дархан, Айраг зэрэг сумын төвүүдийн ус хэрэглэгчдэд өгөхөөр урьдчилан төлөвлөж байна.

Алтай хотын одоогийн хэрэглэж буй усны эх үүсвэр чанар болон нөөцийн хувьд хангалтгүй байгаа юм. Төслөөр Тайширын УЦС-ын усан сангаас УЦС-ын үйл ажиллагаа, усны нөөцөд ямар нэг сөрөг нөлөөгүйгээр, эргийн далд байгууламжаар усыг шүүрүүлэн авч 55 км урт, 250мм голчтой далд яндан хоолойгоор дамжуулан Алтай хотын усан санд хүргэнэ. Алтай хот болон яндан хоолойн дагуух уст цэгийн нийт ус хэрэглээ 2030 оны түвшинд 47.8 л/сек буюу 1.26 сая.м³/жил, 2040 оны түвшинд 70.8 л/сек буюу 1.86 сая.м³/жил болно. “Гэгээн нуур”-ын усан сангаас авахаар төлөвлөж байгаа усны хамгийн их хэмжээ нь **усан сангийн усан толионоос уурших ууршилтын хэмжээнээс 2030 оны түвшинд 30 дахин, 2040 оны түвшинд 20 дахин**




Туул, Тэрэлж голын урсацад тохируулга хийж, олон зориулалтаар ашиглах усан цогцолбор байгуулах нь 2030-2050 оны түвшинд Улаанбаатар хотын ус хангамжийн хэрэгцээг хангах, Туул, Тэрэлж голын экосистемийг хамгаалах, үерийн эрсдэл, газрын доорхи усны хомсдол, түвшний бууралтаас сэргийлэхэд чухал ач холбогдолтой.

Одоогийн Улаанбаатар хотын ус хэрэглээ дунджаар 225 мянган м³/хоног байгаа ба гэр хорооллуудыг барилгажуулах шинэ бүтээн байгуулалт, орон сууцны төсөл хөтөлбөрүүдтэй холбоотой хэтийн төлөв байдлаас харахад **2030 онд энэ хэрэглээ 2,3 дахин, 2050 онд 3,2 дахин өсөх** тооцоо гарч байна.

Туул голд урсацын тохируулга хийх замаар 6%-ийн урсацыг унд ахуйн хэрэгцээнд авч ашиглана гэж тооцоход ойролцоогоор **120 мян.м³/хон** буюу жилд 45,0 сая.м³ ус ашиглаж болохоор байна.



бага гарч байна. Энэ нь УЦС-ын эрчим хүч үйлдвэрлэх үйл ажиллагаа болон хүрээлэн буй орчин, байгаль экологийн хувьд ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй болохыг илэрхийлж байна.



ДУЛААНЫ V ЦАХИЛГААН СТАНЦ

Улаанбаатар хотыг дулааны шинэ эх үүсвэрээр хангах V цахилгаан станцыг барих эрчим хүчний төсөл хэлэлцээрийн шатанд шилжсэн. Тус төслийг Концессын хуулийн дагуу уралдаант шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулж, хуулийн этгээдтэй хэлэлцээрийг үргэлжлүүлэн хийсэн. Төсөлд шаардлагатай нийт санхүүжилт нь урьдчилсан байдлаар 1.4 тэрбум ам.доллар. Энэ онд багтан V ДЦС-ын эхний блокыг барьж ашиглалтад оруулахаар төвлөсөн. Тус станц нь жилд хоёр сая тонн орчим нүүрс хэрэглэх аж. Энэхүү нүүрсний хэрэглээ нь манай улсын нүүрс олборлолтыг нэмэгдүүлж, салбарын хөгжилд томоохон туслалцаа үзүүлэх юм. Цахилгаан станцыг Баянзүрх дүүргийн 11-дүгээр хорооны нутаг дэвсгэр болох Хөлийн голын хөндийд байгуулахаар Засгийн газраас баталсан. Станцын хүчин чадал нь 450 мвт.





Ногоон ДНБ

Бид ногоон дэлхийтэй байсан. Тув тунгалаг цэвэрхэн гол горхины эзэн нь байсан. Өвс найгасан талд солонго татахыг харан баясдаг байсан. Бүгд байсан, байсан. Хожим ямар дүр зурагтай болсныг бид мэднэ. Дэлхийн улс орнууд урьд өмнө нь зөвхөн эдийн засгийн өсөлт гэдэг ойлголтоор аливаа хөгжлийг төсөөлдөг байсан. Түүндээ хүрэхийн тулд ногоон бүхнээ устгасан. Тэгвэл одоо ногоон өсөлт гэсэн ойлголтыг бий болгох, түүнийг хөгжлийн гол чиг баримжаагаа болгохоор зорьж байна.

МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш Б.Бадамцэцэг “Ногоон эдийн засаг ба албан ёсны статистик” судалгаанд “Ногоон эдийн засаг гэж байгаль, хүрээлэн буй орчинд учирч буй эрсдэл, экологийн тэнцвэргүй байдлыг үр дүнтэйгээр бууруулах замаар нийгмийн сайн сайхан, баялгийг бүтээх цогц ойлголт юм. Өөрөөр хэлбэл, хүний буруутай үйл ажиллагааны улмаас сүйдсэн байгаль, хүрээлэн буй орчинг хамгаалж, түүнийг хамгийн үр дүнтэй байдлаар ашигласнаар ядуурал, ажилгүйдлээс ангижирч тогтвортой хөгжилд хүрэх цорын ганц арга хэлбэр гэж эрдэмтэд тодорхойлж байна” хэмээн онцолжээ. Ногоон эдийн засгийг хөгжиж буй орнуудад хэвшүүлэх нь хөгжингүй орнуудад хэрэгжүүлснээс илүү хялбар байдаг аж. Эдийн засгийн тогтвортой хөгжлийн тухай ойлголтыг судалгаанд доорх үндсэн зарчмаар тулгуурлан тодорхойлжээ. Үүнд,



1. Хүлэмжийн хийн ялгарал багатай
2. Эрчимийн зарцуулалт багатай
3. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон байх
4. Ногоон технологи ашигласан байх
5. Ногоон үйлдвэрлэл хөгжүүлэх, ногоон бүтээгдэхүүн үйлдвэрлэх
6. Ногоон орчин, ногоон тээвэр ашиглах
7. Амьдралын “ногоон” хэрэглээг бий болгох, орчин бүрдүүлэх, хэвшүүлэх
8. Ногоон ажлын байр бий болгох

Солонгос улс хөгжлийн зорилгоо “Хүлэмжийн хийг хамгийн бага түвшинд байлгаж, эдийн засгийн өсөлтийг хангах” гэж тодорхойлжээ. Тус улс нь эрчим хүчний хэрэглээгээрээ дэлхийд эхний аравт орох бөгөөд эрчим хүчний хэрэглээнийхээ дийлэнхийг импортоор хангаж байна. Үүнээс үүдэн эрчим хүчний бүтээгдэхүүний үнэ өсч, ихээхэн хэлбэлзэл үүсч эхэлжээ. Цаг агаарын өөрчлөлтийн хувьд Солонгосын томоохон зургаан хотын агаарын температур, хур тунадас олон жилийн дунджаас нэмэгдэж, ой, ойт хээрийн бүсэд экосистем алдагдаж, үер ус, байгалийн гамшиг нь эдийн засаг, нийгмийн амьдралд сөрөг нөлөө үзүүлэх болжээ. Энэ бүгдээс эдийн засгийн өсөлтийн хурдац нь саарч байна.

Харин манай үрд хөрш ногоон эдийн засгийг

хөгжүүлэх чиглэлээр багагүй ажлуудыг эхлүүлсэн бөгөөд 2015 он гэхэд ногоон эдийн засгийн голлох салбаруудад 468 тэрбум ам.долларыг оруулахаар төлөвлөж байна. Хятад улс ногоон эдийн засгийг хэмжих үзүүлэлтийн системийг дараах байдлаар бүрдүүлж байна. Үүнд;

1. Нэг хүнд ногдох ДНБ
2. Шинэ технологи нэвтрүүлсний үр дүнд бий болсон нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь
3. Нэгж ДНБ-д ногдох нөөцийн хэрэглээ
4. Нэгж ДНБ-д ногдох хүлэмжийн хийн ялгаралт
5. Төрийн үйлчилгээ
6. Судалгаа шинжилгээний зардлын ДНБ-д эзлэх хувь

Тив алслан орших Австрали улсын статистикийн байгууллагаас хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах чиглэлээр Австрали, Хятад, Герман, Энэтхэг, Япон, Шинэ Зеланд, Өмнөд Солонгос, Англи, Америк зэрэг орнын 1000 гаруй бодлогын шийдлийг судалсан байна. Тэдгээр бодлогыг дараах чиглэлээр хэрэгжүүлж байна. Үүнд;

1. Нүүрстөрөгчийн үнэлгээ зохистой тогтоох
2. Сэргээгдэх эрчим хүчний түвшинг тогтоох, технологийн стандарт болон эрчим хүчний үр ашгийг тодорхойлох, холбогдох хууль дүрмийг бий болгох зэргээр хяналтын механизмыг бүрдүүлэх,
3. Судалгаа шинжилгээний ажлыг дэмжих, өргөжүүлэх,
4. Татвар, татаасын хэмжээг оновчтой тогтоох,
5. Тодорхой үйл ажиллагаанд зарцуулах шууд зардлуудыг авч үзэх.

Австрали улсын Засгийн газраас 2020 он гэхэд хүлэмжийн хийн ялгаралтын түвшинг 2000 оны түвшингээс таван хувиар бууруулахаар зорилго тавьжээ.

Байгаль орчны статистик /БОС/-ийг хөгжүүлэх үйл ажиллагааг Энэтхэг улсад 1981 оноос статистикийн байгууллагын санаачилгаар эхэлжээ. Үүнээс хойшхи хугацаанд шат дараалсан олон арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. 1985 онд улсын түвшний мэргэжлийн байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг байгуулж, 1990 онд байгаль орчин, ногоон эдийн засгийг тооцож, тодорхойлох үзүүлэлтийн хүрээг тодорхойлжээ. Мөн 1996 онд БОС-ийн удирдах улсын хороог байгуулсан нь ногоон эдийн засгийг хөгжүүлэх институцийн хөгжилд дорвитой ахиц болжээ. Энэтхэг улс байгаль орчин, байгалийн нөөцийн данс байгуулах гурван шатны ажлыг одоо хийж байна. Үүнд;

1. Биет хэмжээний данс байгуулах
2. Мөнгөн үнэлгээний данс байгуулах
3. Эдийн засгийн нэгдсэн данс байгуулах

Дээрх гурван шатны ажлын хүрээнд байгуулсан биет хэмжээний дансыг үнэлж, мөнгөн дүнгээрх данс байгуулаад, үр дүнд нь байгалийн нөөцийн цэвэр өөрчлөлтийг тооцож, улсын хэмжээний ногоон дотоодын нийт бүтээгдэхүүн /НДНБ/-ийг тооцох ажлыг одоо хийж байна. Энэтхэг улс өнгөрсөн хугацаанд судалгааны олон ажлыг хийж байгаа бөгөөд энэ ажилд эрдэм шинжилгээний институци, их дээд сургуулидыг өргөнөөр татан оролцуулж байгаагаараа онцлог аж.

Дээрх орнуудын жишгээр Мексик улс 2003 оноос эхэлж НДНБ-ий тооцооллыг хийж, эдийн засгийн өсөлт нь байгаль орчны нөлөөлөлтэй хэрхэн уялдаж байгааг тодорхойлсон байна. 2009 оны байдлаар тус улсын НДНБ, ДНБ-ий харьцаа 92.4 хувь байна гэж тооцжээ.



ОЙ МОДНЫ ТУХАЙ

Анхны асар том намган ойд ойролцоогоор 350-280 сая жилийн тэртээ үүсч бий болжээ. Тэр ойд өнөө үед чулуун нүүрс болон үлдсэн, төрөл зүйлс устаж үгүй болсон модод ургадаг байж. Олон сая жилийн явцад анхны моддын төрөл зүйл болох Стдко болон шилмүүст МОДОД - намгийн майлаас, хар мод бүхий ойд бүрэлдэн үүссэн байна. Харин навчит модод болох эвэр мод, бургас, царс, нүргэс модод барагцаалбал 60 сая жилийн өмнөөс л үүсэн бүрэлджээ. Ойролцоогоор нэг сая жилийн өмнө анхны том хэмжээний ойн мөхөл мөстлөгийн үеэс манай тооллоос өмнөх 8000 жилийг хүртэл үргэлжилсэн гэдэг.

Тэр үед төв европт хус, царс, хайлаас, агч болон бодь мод гэх мэтийн модод л үлдэж, мянган жилийн дараагаар л эвэр болон гацуур модод нөхөн ургаж эхэлжээ. Хүн төрөлхтний хувьд ой мод эхлээд төрөлх гэр нь байснаа аажмаар тэд жим гарц гарган ойн зах руу нүүдэллэн амьдрах болжээ. Гэсэн хэдий ч тэдний ой мододтой харьцах холбоо нь маш чухал хэвээр байсан юм.

Манай тооллоос 9000-аад жилийн өмнө хус амьдралын чухал хэрэгцээт ургамал байжээ. Түүний холтсыг шир адил эвлүүлэн зүйж оёж бөхлөөд анчид завь болгон ашиглана. Хусны давирхай наалдамтгай зөөлөн эдтэйгээ нийлж хавар цагт холтосны доторхи давхарга нь уургаар баялаг талх барихад нэн тохиромжтой болно. Хусны шүүсийг зөгийн балтай холин эсгэж согтууруулах ундаа гарган авна.

ОЙ МОДНЫ АШИГ ТҮС

Ой мод нүүрсхүчлийн хийг шингээж, хүчилтөрөгчийг үйлдвэрлэдэг гэдэг нь тодорхой зүйл. Харин хэдий хэмжээтэй гэдэг асуултын хариултыг хэн бүхэн мэдэхгүй. Яг тодорхой хэлэхэд төвөгтэй л дөө. Учир нь ой болгон харилцан адилгүй байдаг. Жишээ нь халуун орны ой жилийн дөрвөн улиралтай газрын ой моддоос хэдэн хувь илүү түргэн өсөж ургадаг. Тэр утгаараа халуун орны ой яг адилхан хугацаанд илүү их хэмжээний нүүрсхүчлийн хийг шингээдэг гэсэн үг. Тиймдээ ч дэлхийн уушиг гэгддэг байх нь. Бас ойн хөрс ч нүүрсхүчлийг сордог гэдэг ч энэ тал дээр хийсэн судалгааны тодорхой тоо алга. Фотосинтезийн үзэгдлийн явцад модны навчис агаараас нүүрсхүчлийн давхар ислийг өөртөө шингээн авдаг.

Нарны гэрэлд ургамлын навчинд нүүрсхүчлийн хий болон агаарт буй ус исэлдэн нийлэгжсэний үр дүнд саахар (глюкоз буюу цардуул) болон хүчилтөрөгч үүсч бий болдог фотосинтезийн энэ үзэгдлийг томьёолбол. $6\text{CO}_2 + 12\text{H}_2\text{O} \rightarrow \text{нарны гэрэл, ногоон навч} \rightarrow \text{C}_6\text{H}_{12}\text{O}_6$ (Глюкоз) + 6O_2 (Хүчилтөрөгч) □*. 6CO_2 - Агаар дах нүүрсхүчлийн давхар ислийн хэмжээ

12 H₂O-Агаарын чийгшил дэх усны хэмжээ.

Ургамалд өөрт нь бол энэ үзэгдлээс хоол тэжээлийн үүрэг гүйцэтгэх цардуул хэрэгтэй бөгөөд хүчилтөрөгч энэ тохиолдолд зөвхөн ялгарч гарсан бодис бөгөөд энэ нь амьд организмын амьсгалах цэвэр агаар болж өгдөг.

ОЙ МОД ГОМДОЖ, БАС ҮЙЛДАГ

Энэ дүгнэлтийг Японы биологич эрдэмтэн ноён Нишизакийн туршилт ч нотолж өгнө. Тэрээр таван жилийн турш хоёр гадил модыг хоёр өөр аргаар арчилжээ. Нэг модыг нь амин дэмээр тордож, үргэлж арчилж тордон, уянгалаг сайхан аялгуу сонсгодог, харин хоёр дахь модыг нь саваагаар цохидог, цахилгаан гүйдэл гүйлгэн, хүнцэл гэдэг хороор шүршдэг байжээ. Эрдэмтнийг ойртож очиход эхний мод нь навчсаа дэлгэн, “инээмсэглэж буй” мэт найган угтдаг бол харин хоёр дахь мод нь эрдэмтнийг “хатгах” гэдэг байжээ. Үүнийг нь кино хальсанд буулган авсан байна. Энэ бол эрдэмтдийн хийсэн судалгаа юм. Тэгэхээр мод өөрт нь хүн хэрхэн ханддагийг мэддэг байх нь.

Ой модонд хайр найргүй хандах бүрийд мод “өширхдөг” тухай таамаглал шинэ зүйл биш гэдгийг олон эрдэмтэн нотолдог. Ургамлын дээд хэсэг нь хүний уураг тархитай адилхан гэж эрдэмтэн Ч.Дарвин бичсэн нь бий. Мод ургаж, навч нахиагаа дэлгэдгээс гадна хүний бусармаг үйлдэлд гомдон “үйлдэг” байна. Энэ тухай Олон улсын байгаль хамгаалах холбооноос нийтэлж гаргасан Англи улсын Лондоны биологийн хүрээлэнгийн доктор Батти Лахири хэмээх эрдэмтний илтгэлд дурдсан байдаг.

ХАМГИЙН, ХАМГИЙН

Дэлхийн хамгийн өндөр мод: Цөлийн заан мод (5едио1а зетреплгепз) Америкийн Калифорн дахь Редвоод үндэсний цэцэрлэгт хүрээлэнд ургаж байгаа 115,5 метр өндөр, 2000- аад жилийн настай.

Хамгийн саглагар мод: Америкийн Калифорнийн Секоя үндэсний цэцэрлэгт хүрээлэн дэх Заан мод (Зедио1а зетреплгепз) мөчир навчисын хамт (титэм гэж нэрлэдэг) дунджаар 1489 кубметр өргөн, 1385 тонн хүнд, 2500 гаруй жилийн настай аж.

Хамгийн бүдүүн мод: Мексикийн Санта мариа дел Туле дахь намгийн майлаасны (ТохосНит Мисгопашт) иш нь хамгийн өргөн хэсгээрээ 14,05 метрийн тойрогтой байна.

Хамгийн хөгшин мод: Америкийн Калифорн дахь цагаан ууланд 4800 гаруй жилийн настай нарс (Ртиз 1_апдаеуа) бүртгэгдсэн байна. 2008 онд Швед Улсад олдсон нэгэн гацуур модны ёзоор 9550 жил болсон, эргэн тойрныхоо мододтой генийн ижил шинж тэмдэгтэй болох нь тогтоогдсон байна. Манай орны хувьд 800 жилийн настай шинэс олдсон нь хамгийн хөгшин модонд тооцогдож байна.

Хамгийн хүйтэнд тэсвэртэй мод: Дагуурын шинэс (1_апх дтеПпп) болон зүүн азийн тарваган хуш (Ртиз риггпа) нь хасах 70 хэмийн хүйтнийг тэсвэрлэн амьдарсаар байсан аж. Дагуурын шинэсний энэ зүйл бас манай орны ойд ургадаг.

Хамгийн өндөрт ургадаг мод: Далайн төвшнөөс 4600 метрийн өндөрт зүүн Гималайн ууланд ургадаг Жодоог (Аб-1ез здиата1а) хэлж болно.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ

Та эрчим хүчинд илүү үр ашигтай технологийг ашигласнаар гэрэлтүүлэгт зарцуулдаг эрчим хүчний зардлаа 50%-иар багасгах боломж бий. Үүний тод жишээ нь улайсдаггүй чийдэн бөгөөд та үүнийг ашигласнаар жилд 68,1 кг нүүрстөрөгчийн давхар исэл агаарт ялгарахаас сэргийлнэ.



Эрчим хүчний яамнаас 2013 оныг Эрчим хүчний хэмнэлт-үр ашгийн жил болгон зарласан билээ.

Манай улсын эдийн засаг эрчимтэй хөгжихийн хэрээр эрчим хүчний хэрэглээ өсөн нэмэгдэж 2012-2013 оны өвлийн ид ачааллаар Төвийн эрчим хүчний системийн ачаалал 880-890 МВт хүрэх магадлалтай байгаа юм.

Эрчим хүчний салбарт томоохон хэмжээний эх үүсвэрүүдийг ашиглалтад оруулах бодлогын ажлууд хийгдэж байгаа ч эрчим хүчний хэрэглээний эрэлтийг бүрэн хангахад хүрэлцэхгүй нөхцөл байдал бий болоод байгаа үед эрчим хүчийг үр ашигтай хэрэглэх нь чухал байгааг яамны удирдлагууд хэлж байна.

Эрчим хүчний сайд М.Сономпил “Энэ оныг эрчим хүчний хэмнэлтийн жил болгохдоо эрчим хүчний салбарынхан бид өөрсдөөсөө эхлэхээр ажиллаж байна.

Эрчим хүчний үйлдвэрүүд дотоод нөөц бололцоогоо ашиглан алдагдлаа бууруулж зардлаа хянахаар төлөвлөж дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулаад байгаа. Яамны зүгээс 2013 онд Эрчим хүчний үйлдвэрүүдийн дотоод хэрэгцээнд зарцуулж байгаа цахилгаан эрчим хүч, дамжуулах, түгээх сүлжээнүүдийн техникийн болон арилжааны алдагдлыг бууруулах, менежментийг сайжруулж, өртөг зардлыг бууруулж үр ашгийг дээшлүүлэх технологиудыг нэвтрүүлэх, нутагшуулахаар арга хэмжээ авч ажиллана” гэв. Мөн иргэд, аж ахуйн нэгжүүд цахилгааныг зүй зохистой хэрэглэснээр төлбөрийн зардлаа бууруулахаас гадна улс орны эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг хангахад хувь нэмрээ оруулах болно. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагууддаа эрчим хүчийг зүй зохистой хэрэглэж, “Эрчим хүчний хэмнэлт-үр ашгийн жил”-д нэгдэхийг салбарын яамнаас уриаллаа.

Монгол Улсад иргэд өдөр тутмынхаа амьдралд бараг дийлэнх нь эрчим хүч хэрэглэдэг. Бид эрчим хүчний эх үүсвэрээр нүүрсийг ашигласнаар ирсэн. Нүүрсээр эрчим хүч үйлдвэрлэсний дүнд хүлэмжийн хий ихээр ялгарч байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсээр байна.

Эрчим хүчний үр ашгийг бий болгох олон арга замууд байдаг. Ингэснээр та эрчим хүчний зардлаа хэмнэн үүгээрээ байгаль орчин, ирээдүйгээ хамгаалах юм.

Зардлаа зохицуулах

Өрхийн зарлагын ихэнх хувь нь цахилгаан болон шатахууны зардалд зарцуулагддаг. Та энэхүү байдлыг зохицуулж чадахгүй ч танд зардлаа багасгах чадал бий.

Та юу хийж чадах вэ?

Эрчим хүчний хэрэглээгээ багасгах хялбар, бодит, боломжит алхмууд бий. Гэвч та бүгдийг заавал хийх албагүй, та өөрт байгаа бага ч гэсэн боломжийг ашиглахад өөрчлөлт мэдэгдэх болно. Ихийг хийх тусам төдий чинээ хэмнэлтийг та эдлэх болно. Ямар ч өртөггүйгээр эхлэх боломжууд мөн бий.

Жишээ нь шаардлагагүйгээр гар утас, зөөврийн компьютер цэнэглэж орхихгүй байх, угаасан хувцсаа хатаагчаар бус нар салхинд тавин хатаах. Та худалдан авалт хийхдээ бага ус, эрчим хүч зарцуулдаг бүтээгдэхүүнийг сонгосноор эрчим хүчний зардлаа багасгах боломжтой.

Гэрэлтүүлэг

Та эрчим хүчинд илүү үр ашигтай технологийг ашигласнаар гэрэлтүүлэгт зарцуулдаг эрчим хүчний зардлаа 50%-иар багасгах боломж бий. Үүний тод жишээ нь улайсдаггүй чийдэн бөгөөд та үүнийг ашигласнаар жилд 68,1 кг нүүрстөрөгчийн давхар исэл агаарт ялгарахаас сэргийлнэ.

Халаалт болон хөргөлт

Өрх айлын эрчим хүчний хэрэглээ нь ойролцоогоор 38% нь халаалт болон хөргөлтөнд зарцуулагддаг. Хэрэв та шинэ байр барих гэж байгаа бол эрчим хүчний үр ашигтай байдлыг юуны түрүүнд бодох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, дулааны тохируулга ашиглах хэрэгтэй. Дээвэр, хана, цонхоор их хэмжээний дулаан алддаг. Жишээ нь, өвөл гэрийн дулааны бараг 40 хувийг алддаг. Тиймээс эдгээрийг зөв тооцоолсноор эрчим хүчний зардлаа багасгахын хажуугаар хүлэмжийн хийг бага ялгаруулан эдийн засгийн хувьд хэмнэлттэй амьдрах боломжийг Танд олгоно.

Сэргээгдэх эрчим хүч

Сэргээгдэх эрчим хүч нь нар, салхи, усыг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх үйл ажиллагааг хэлнэ. Монголд хамгийн ашиглах боломжтой сэргээгдэх эрчим хүч бол нарны эрчим хүч юм. Учир нь монгол улсад дунджаар жилд 230-260 өдөр өөрөөр хэлбэл, 2600-3300 цаг үүлгүй нарлаг өдрүүд байдаг.

Ногоон буюу цэвэр эрчим хүч

Ногоон буюу цэвэр эрчим хүч гэдэг нь нар, салхи, ус мөн органик хог хаягдлыг ашиглан цахилгаан үйлдвэрлэх үйл ажиллагаа юм. Нүүрснээс эрчим хүч үйлдвэрлэх болох уламжлалт аргаас татгалзан, цэвэр эрчим хүч ашигласнаар та байгаль орчны доройтлыг бууруулахад өндөр хувь нэмэр оруулна.

Нарны эрчим хүч гэж юу вэ?

Нарны эрчим хүч гэдэг нь нарны туяаг нарны зай



хураагуур (301ag paper)-ын тусламжтайгаар цахилгаан эрчим хүчинд хувиргах арга юм. Нарны зай хураагуурын өртөг хэдий үнэтэй ч удаан хугацааны дараа таны нийт төлөх цахилгааны зардлаас хавьгүй хямд тусна, мөн байгаль орчинд ээлтэй.

Салхин эрчим хүч гэж юу вэ?

Салхин эрчим хүч нь агаарын урсгалыг сэнс буюу салхин турбинийг ашиглан эрчим хүч үйлдвэрлэхийг хэлнэ. Салхин эрчим хүчийг өндөрлөг салхи ихтэй газар байрлуулдаг учир энэ нь хот суурийн болон хөдөө тал хаана ч байрлуулахад тун тохиромжтой.

Ахуйн эрчим хүчний үр ашигтай байдал

Улс орон хөгжин, хүн ам ихсэхийн хэрээр эрчим хүчний хэрэглээ улам ихэсч байна. Үүнийг даган ахуйн бүтээгдэхүүн хэрэглээ ихэссэн. Та хаана амьдардаг ч бай эрчим хүчинд үр ашигтай гэр ахуйн бүтээгдэхүүн хэрэглэн эрчим хүчээ хэмнэх боломж бий. Таны гаргасан шийдвэр эрчим хүчний зардалд олон жилийн турш эерэгээр нөлөөлнө.

Цахилгаан эрчим хүчийг хэмнэлттэй ашиглах зөвлөгөө

1. Ердийн улайсах чийдэнг люминесценц болон неон гэрлээр солиход гэрэлтүүлгийн чанар эрс сайжрах ба гурав дахин бага эрчим хүч зарцуулахаас гадна ашиглалтын хугацаа улайсдаг чийдэнгийнхээс уртасдаг.

2. Цонхны шилийг угааж байнга цэвэр байлган байгалийн гэрэлтүүлэг ашигласнаар гэрэлтүүлэгт зарцуулах цахилгааныг зуны улиралд цагт 90, өвлийн улиралд цагт 15 хүртэл хувиар бууруулах боломжтой.

3. Гар хийцийн стандарт бус плитка хэрэглэх нь гал түймрийн аюултайгаас гадна цахилгаан эрчим хүчийг маш ихээр үр ашиггүй зарцуулахад хүргэдэг.

4. Цулгүй ширэмтэй плитканы оронд цагираг хэлбэрийн гүүрсэн халаагчтай "Мечта" маягийн цахилгаан зуух хэрэглэхэд цахилгаан эрчим хүчийг 5-10 хувиар хэмнэнэ.

5. Хоол бэлтгэх сав нь таарсан тагтай, тэгш хавтгай ёроолтой, ёроолын гадаргуугийн хэмжээ нь цахилгаан зуухны ширэмний хэмжээтэй адил, сав суулганы ёроол үргэлж цэвэрлэж байх нь цахилгааныг хэмнэх ач холбогдолтой. Хоол цай бэлтгэх сав суулганы ёроол дотогшоо хонхойсон, эсвэл гадагшаа төмбийсөн үед цахилгаан эрчим хүчийг 40-60 хувиар, хэмжээ нь плитканы ширэмний хэмжээнээс бага үед 15 хүртэл хувиар илүү зарцуулахад хүргэдэг.

6. Хөргөгчийн хаалгыг олон дахин нээх буюу удаан хугацаагаар онгорхой орхих нь цахилгаан эрчим хүчний хэрэглээг ихэсгэдэг тул зөвхөн шаардлагатай үед онгойлгож, тэр даруйдаа хааж байх нь цахилгаан эрчим хүч хэмнэх бас нэг нөхцөл болно.

7. Ажлын байрыг цайвар өнгөөр будах нь намар, өвлийн улиралд цахилгаан эрчим хүчний хэрэглээг 5-15 хувиар бууруулдаг.

8. Тоног төхөөрөмжийн эргэх хэсгийн тосолгоог заавар дүрмийн дагуу, чанартай, тогтмол хийвэл хөдөлгүүрт хэрэглэж буй цахилгаан 10 хувь, цахилгаан гагнуурын аппаратын засвар үйлчилгээг сайн хийж

техникийн зохих горимоор ажиллуулбал цахилгааны зарцуулалт 30 хүртэл хувиар багасдаг.

9. Мэдээлэл холбооны хэрэгслүүд телевизор, систем хөгжим, радио, компьютер, принтер зэрэг нь харьцангуй бага чадалтай ч удаан хугацаагаар ашиглагддаг тул цахилгаан эрчим хүчийг тодорхой хэмжээгээр зарцуулдаг ба цахилгаан хэрэгслүүдийг ашиглаж дуусангуутаа цахилгаан залгуураас салгаж бүрэн унтрааснаар цахилгаан эрчим хүч хэмнэгдэх нэг нөхцөл болно.

ГАДНЫ ТУРШЛАГА

Гурваас дээш жил явсан бөгөөд агаар гаргаж байгаа бохирдлыг хэмжин түүнд нь өндөр татвар ногдуулдаг байсан. Энэ нь автомашинаас ялгарах утааг багасгахамгийн үр дүнтэй арга хэмжээ байсан. Олон жилийн хугацаанд шат дараатайгаар арга хэмжээ авсны үр дүнд бид агаарын бохирдлыг бууруулж чадсан.



Япон улсын Саппоро хотын дарга Уеда Фүмио: БИД ЦАСЫГ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭХ ҮҮСВЭР БОЛГОН АШИГЛАДАГ

Улаанбаатар хотод би анх удаа ирж байна. Агаарын бохирдол хүнд байгаа нь харагдаж байна. Улаанбаатарын агаарын бохирдол, байгаль орчны хүндрэлтэй асуудлууд хот руу чиглэсэн тасралтгүй шилжилт хөдөлгөөнөөс хун амын нягтшил хэт ихэссэнтэй холбоотой гэж бодож байна. Өвөл болдог хот маш хүйтэн, цас их ордог. Энэ нь нэг талаар бэрхшээл боловч үүнийг байгалийн баялаг болгон ашиглаж бас болдог. Жишээ нь, манай хотод цас ихээр хунгарлан ордог. Түүнийг арилгахад зардал их орно. Гэвч цас ордоггүй газрын хүмүүсийн сонирхлыг энэ нь ихэд татдаг. Саппоро хот энэ жил 63 дахь удаагаа цасны баяр зохион байгуулж байна. Энэ баяраар гадны жуулчдаас гадна Японы бусад хотоос олон хүн ирдэг. Тэгэхээр цас бол аялал жуулчлалын нэг бүтээгдэхүүн болж чадаж байна. Хоёрдугаарт бид цасыг эрчим хүчний эх үүсвэр болгон ашиглаж байгаа. Их хэмжээгээр хунгарлан орсон цасыг хадгалдаг. Хавар болоод хайлах явцад ялгарах эрчим хүчийг нь агааржуулалтын системд ашиглаж байна. Гуравдугаарт ургамал, хүнсний ногоо хадгалах зоорь болгон ашиглаж байгаа юм. Энэ мэтчилэн цасыг баялаг болгон ашиглах боломж олон бий. Нүүрсээр дулаан, цахилгаанаа үйлдвэрлэж байх үед утаа асуудал болж байсан. Тиймээс Япон даяар эрчим хүчний хувьсал хийсэн. Бид нүүрс биш, нефть боловсруулж эрчим хүч, дулаан гаргадаг болсноор утааны асуудал бүрэн шийдэгдсэн. Түүнээс гадна нүүрс ашигласан ч агаар бохирдуулдаггүй яндангийн шүүлтүүрийн технологи маш өндөр түвшинд хөгжсөн.



Эстони улсын Вимши хотын дарга Халдо Оравас: МОНГОЛД НАР, САЛХИ АЛЬ АЛЬ НЬ БАЙНА

Манай улсаас Монголд цөөхөн хүн ирж байсан тул Монголын талаарх миний мэдлэг интернэтийнхээс хэтрэхгүй байсан. Харин ирээд харахад бахархах сэтгэл төрсөн. Ийм хөгжил дэвшлийг Улаанбаатараас харна гэж бодоогүй. Улаанбаатарт ирээд би нэг зүйлийг их гайхсан. Манай хоёр хот цаг агаарын эрс тэс уур амьсгалтай ч танайд нэг давуу тал байгааг би олж харсан. Өчигдөр бид цанын баазад очиж гулгаж үзэхэд тэр өдөр маш сайхан нартай байсан. Тэгээд би хүмүүсээс асуухад өвөлдөө ихэвчлэн тийм нартай байдаг гэж хэлсэн. Тэр үед би Монгол улс яагаад сэргээгдэх эрчим хүчийг ашиглахгүй байна вэ гэж үнэхээр гайхсан. Манай хотод нартай өдөр ховор. Арваннэгдүгээр сараас эхлээд бүрхэг, нарны тусгал муутай өдрүүд үргэлжилдэг. Харин Монголд салхи, нар аль аль нь байна. Мэдээж хөрөнгө их шаардагдана л даа. Гэхдээ зоригтой алхам хийж, эрчим хүчний энэ чиглэл рүү явах нь хамгийн найдвартай гарц гэж бодож байна.

АНУ-ын Анкорез хотын захирагч Дик Сталлоне: БИД ГУРВААС ДЭЭШ НАСЖИЛТТАЙ АВТОМАШИНД ӨНДӨР ТАТВАР НОГДУУЛСНААР УТААНААСАА САЛСАН

Агаарын бохирдол буюу утаанаас салахад олон жилийн хугацаандтодорхой аргахэмжээ авсны үр дүнд гарч ирнэ. Манай орны хувьд ч гэсэн утаа байсан. Бид яг одоо Улаанбаатар шиг утаатай байсан. Гэхдээ манай улсыг бодвол илүү их агаарын бохирдолтой байна. Одоогийн танай хотын удирдлагуудын хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд буюу утаагүй түлш, утаа бага гаргадаг зуухыг бид ч гэсэн хэрэглэж байсан. Агаарын бохирдол гэр хорооллын утаанаас гадна автомашины утаа болон бусад олон төрлийн зүйлээс шалтгаалдаг. Танай улсын хувьд автомашины утаа бас их нөлөөлж байх шиг байна. Манай улс бол автомашины утааг бууруулах нэгэн арга хэмжээ авсан. Дэлхийн бусад хотууд ч гэсэн энэ арга хэмжээг авсан байдаг юм билээ. Анкорез хотод гурваас дээш жилийн насжилттай автомашин буюу агаарт утаа гаргаж, бохирдуулж байгаа автомашинд торгууль тавьж эхэлсэн. Гурваас дээш жил явсан бөгөөд агаар гаргаж байгаа бохирдлыг хэмжин түүнд нь өндөр татвар ногдуулдаг байсан. Энэ нь автомашинаас ялгарах утааг багасгах хамгийн үр дүнтэй арга хэмжээ байсан. Олон жилийн хугацаанд шат дараатайгаар арга хэмжээ авсны үр дүнд бид агаарын бохирдлыг бууруулж чадсан.

БНСУ-ын Хвачонь хотын дарга Чай Ин Сеок: БИД АГААРЫН БОХИРДОЛ БАГАТАЙ БИО ТҮЛШИЙГ БИЙ БОЛГОСОН

Бид ус, салхи, нар, газрын дулааны эрчим хүчийг ашигладаг. Манай улс ой мод ихтэй, нийт нутгийн 86 хувь нь ой байдаг. Тиймээс бид агаарын бохирдол багатай биотүлшийг бий болгосон. Энэ нь модон бүтээгдэхүүний хаягдлыг тусгай хөрөөгөөр нунтаглаад өндөр градуст, өндөр даралтаар шахаж, нэг хэмжээтэй хийдэг юм. Энэ нь байгальд олон эерэг талтай. Тухайлбал, агаарт маш их хортой хүлэмжийн хийг бууруулах, эдийн засгийн хувьд үр ашигтай, мод огтлохгүйгээр зөвхөн хог хаягдлыг ашиглаж байгаагаараа олон талын ашигтай.

ХЯТАДЫН АРГА

Хятад улс Бээжингийн олимпын бэлтгэл ажлын хүрээнд агаарын бохирдолтой ширүүн тэмцсэн. Аж үйлдвэрүүдийг түр зогсоох, тээврийн хөдөлгөөнийг хязгаарлах шийдвэрийг Засгийн газраас гаргасан байдаг. Бээжин, Тяньжин, Тяньшан зэрэг хотуудыг барилга, уул уурхай, химийн үйлдвэрүүдийг түр зогсоох замаар утаа ялгаруулалтыг 30 хувиар бууруулж, албаны унааны 70 хувийг хөдөлгөөнд оролцуулалгүй, хувийн унааг зөвхөн зөвшөөрөгдсөн өдрүүдэд зорчих шийдвэр гаргаж байв. Уг арга хэмжээний дүнд 3.3 сая машины 50 хувь нь хөдөлгөөнд оролцохгүй байлаа.



Мөн хотын доторх галлагаатай шавар тагзуудыг ч буулгасан. Өмнө нь 2006 онд Хятад-Африкийн дээд хэмжээний уулзалтын үеэр мөн автомашины хөдөлгөөнд хориг тавьж 2.8 сая машины 800 мянга нь гурван өдрийн түрш хөдөлгөөнд оролцоогүй учир агаар мандал дахь азотын ислийг 40 хувиар бууруулсан түүхтэй. Хэдий Эмнести интернэшнл зэрэг олон улсын зарим байгууллагууд хүний эрх зөрчлөө, иргэдийг орон гэргүй, ажил төрөлгүй болголоо хэмээн шүүмжилж байсан ч Хятадын захиргааны ажлууд нь сайн үр дүнд хүргэсэн юм. Тэдний ажиллагаа нь түр зуурын арга байсан хэдий ч агаарын бохирдлыг хүчээр, хурдан хугацаанд бууруулж болох юм гэдгийг бусдад ойлгуулж чадсан.



“Ус гандмань эрдэнэ”

2025 он: Дэлхийн саятнууд хэдийнэ нэг тэрбумд хүрэх нь. Чухам тэр үеэс усны үнэ цэнэ улам өссөөр, цаашлаад нефть бүтээгдэхүүнтэй дүйцнэ. 15 жилийн дараа гэхэд хүн төрөлхтөний гуравны хоёр нь цэвэр усны дутагдалд орно. Өнөөдрийн байдлаар манай гаригийн 2.7 тэрбум хүн усаар гачигдаж эхэлснийг Дэлхийн байгаль хамгаалах сангаас саяхан мэдээлсэн.

2050 он: Дэлхийн нийт хүн амын тоо 9.1-9.2 тэрбумд хүрнэ. Тэр үед хүн төрөлхтний өмнө хоол хүнсний хангамж, нөөц аюулгүй байдлын асуудал дээд цэгтээ тулна. Үүнийг дагаад цэвэр усны хомсдол цэнхэр гаригийг бхэлд нь нөмөрч, байгалийн гамшиг, цөлжилт, сүйрэл хаа сайгүй нүүрлэнэ.


2080 он: Африк тивийн хүн ам 70 дахин өснө. Тодорхой хэлбэл, нэг тэрбумаас 70 тэрбумд хүрнэ гэсэн үг. Биологийн заналхийлэл идэвхжиж, ус, хөрс гээд амьд байгалийн төлөөх дайн дэлхийн улс орнуудын дунд хүчээ авна. Эрдэмтэн, судлаачдын гаргасан тоо баримт, таамаг зөгнөлийн зах зухаас нь танд сонирхууллаа.

Тооны хэлээр:

- ❖ Эрүүл хүн өдөрт 48 аяга ус үүж чаддаг.
- ❖ Хүний биеийн 70 хувийг ус эзэлдэг. Тэгвэл хүн цангахад бие дэх усных нь ердөө нэг хувь алдагдсан байдаг гэнэ.
- ❖ Хүний нэг өдрийн хоол хүнсэнд 2000-5000 литр ус шингэсэн байдаг.
- ❖ Хүн төрөлхтний өнөөдөр ашиглаж буй усны 67 хувь нь хөдөө аж, ахуйн салбарт ашиглагддаг бол ердөө өсөн хувийн бид унд, ахуйдаа ашигладаг байна.
- ❖ Америкчууд өдөрт 25 тэрбум литр усыг бохирын шугамаар урсгадаг.
- ❖ Дэлхий дээр 1000-аас дээш километр урсдаг 177 том гол байдгийн ердөө гурван нь л эх авсан газраасаа цутгал хүртлээ ямар нэгэн саад тогтоггүйгээр урсдаг байна. харин бусад нь 60-80 мянган далан доогуур урсаж, голдиол нь өөрчлөгддөг аж.
- ❖ Дэлхийн гадаргын 70-75 хувийг ус бүрхэж байдаг. Харин уур амьсгалын өөрчлөлт энэ эрчээрээ явбал энэ зууны төгсгөлд дээрх тоо 90 хувь болно.
- ❖ Өнгөрсөн хугацаанд усанд амьдардаг 123 зүйлийн амьтад устжээ.
- ❖ Нэг ширхэг арьсан гутал үйлдвэрлэхэд 8000 литр ус зарцуулдаг. Харин нэг А4 хуудас цаасанд 10 литр ус “шингэсэн” байдаг.
- ❖ Жорлонгийн суултуурын усыг ганц удаа татахад 5-10 литр ус урсдаг бол автомашиныг даралттай усаар угаахад 500 литр ус хаягддаг.

1994-2012 онд дэлхийн усны өдөр ямар уриатай болж байсныг сонирхуулахад

- 2012-Ус ба хүнсний аюулгүй байдал
- 2011-Хотуудын ус
- 2010-Усны чанар
- 2009-Хил дамнасан ус
- 2008-Олон Улсын ариун цэврийн жил
- 2007-Усны хомсдол
- 2006-Ус ба соёл
- 2005-Амьдралын ус 2005-2015
- 2004-Ус ба байгалийн гамшиг
- 2003-Ирээдүйн ус
- 2002-Хөгжилд зориулсан ус
- 2001-Эрүүл мэндэд зориулсан ус-Хариуцлага
- 2000-Хорин нэгдүгээр зууны ус
- 1999-Бүх хүн усны урсгал дор амьдардаг
- 1998-Газрын доорхи ус-Нүдэнд үл үзэгдэх нөөц
- 1997-Дэлхийн ус-Бидэнд хангалттай юу?
- 1996-Цангасан хотуудад зориулсан ус
- 1995-Эмэгтэйчүүд ба ус
- 1994-Усны нөөцөө анхаарах нь хүн болгоны үйлс






ӨНДӨР ТҮВШНИЙ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ НУУЦ НЬ МИКРОБИОЛОГИЙН ЖИЖИГ БИОФИЛМ ЮМ

MSB® цэвэрлэгээний загвар бол Булаг юм. Байгалийн эргэлтээр усыг цэвэрлэнэ. 2 гол нөлөөлөх хүчин зүйлтэй: Нэгдүгээрт цэвэрлэгээний Биофилмийг үүсгэх микро биетүүд байрлах усан дахь чулуунууд. Энэ филмийг чулууны өнгөн хэсгийн гулгамтгай дээрээс харах боломжтой. Хоёрдугаарт системийн аюулгүй ажиллагааг хангах булгийн налуу.

Захсений Бергманн Группын инженерүүд Дресден, Котбус, Кемницийн Техникийн Их Сургуулиудтай хамтарч энэхүү механизмийг тодорхойлж, MSB® цэвэрлэгээний цэвэрлэх технологи болгож чадсан.



Тээвэрлэгч материалаар чулууг орлуулсан.

Булгийн-хайрга чулууны оронд тусгайлан бүтээсэн \Л/5В® цэвэрлэгээний микро биетүүд байрлах тээвэрлэгч материалууд „КаИпез К1” ба „КаШпез К2” нь маш оновчтой шийдэл болж чадсан. Тээвэрлэгч нь хэдий жижиг хэмжээтэй ч гэсэн микро биетүүд өсөх хангалттай талбайтай ба удаан хугацааны өндөр түвшний цэвэрлэгээг хийх Биофилм үүсэх нөхцөл бүрэн бүрдсэн. Үүнээс гадна тээвэрлэгч материалын оновчтой эргэлдэх хөдөлгөөнийг үүсгэх агааржуулалт, завсарлага 2-ын ээлжлэх дарааллыг зохицуулах ажиллагааны горимтой. Биологийн цэвэрлэгээний үед усны доод хэсэгт агаар оруулахгүйгээр агаар үлээж эргүүлэх чадалтай. Агааржуулалтын интерваллд үүсэх эргүүлэг нь тээвэрлэгч материалыг өөрөө өөрийгөө цэвэрлэх боломжийг бий болгоно. Ингэснээр өсөх биетүүд хэт их өсөхгүй ба солих эсвэл цэвэрлэх шаардлагагүй.

Бэхэлгээ нь онцгой үед батлагдана.

Тээвэрлэгч материал дээр байрлах Биофилм нь ачааллыг даахуйц их хэмжээний нөөцтэй байна. Эдгээр нь гэрбүлийн баярын үеэр эсвэл усыг их хэмжээгээр хэрэглэх үед шаардлагдана. Одоо таны байгууламж их хэмжээний ачаалалтай ажиллах боломжтой. \WSB® цэвэрлэгээний хувьд ямар ч асуудал байхгүй.


Бүрэн цэвэрлэгээний үед 3 тасалгаа шаардлагатай.

1 төрлийн сав нь 3 тасалгаатай: эхнийх нь түүхий

бодисуудыг тунгаахад зориулагдсан анхдагч тунгаагуур юм. Үүнээс гадна энэ тасалгаа нь лаг хадгалагчийн үүргийг мөн гүйцэтгэнэ. Механикаар цэвэрлэгдсэн ус нь биологийн цэвэрлэгээний шатанд шилжинэ. Энд Биофилм нь хорт бодисуудыг устгана. Дараа нь цэвэрлэгдсэн ус дээж авах цэг буюу тунгаагч худаг руу ус урсан орох хоёрдогч тунгаагуур луу шилжинэ. Зарим нийлүүлэгчид өөрийн системийг 2 тасалгаатай болгодог, ингэснээр тэд бохир усны тогтмол хуваарилалтыг алдагдуулж байна гэсэн үг. WSB® цэвэрлэгээний 3 тасалгаа нь цэвэрлэгээг бүрэн хийх чадалтай гэсэн үг. P1M EM 12566-3 заавраар

Хамгийн сайн зүйлсүүд үнэн хэрэгтээ маш хямд байдаг.

WSB® цэвэрлэгээний бүрэн хэмжээний цэвэрлэгээ маш хялбар: Байгууламжийг амархан элэгддэг, мэдрэмтгий техникээр тоноглодоггүй. Яагаад гэвэл ус өөрийн урсгалаар урсдаг учраас байшин руу ус буцаж урсаж орох боломжгүй. Үүнээс гадна завсрын хадгалагч шаардлагагүй. Хамгийн ашигтай нь ажиллагааны зардал маш бага. Энд бүх л цэвэрлэх байгууламжид гарахтай ижил хэмжээний зардал гарна. Лагийг жилд нэг удаа соруулж гаргах шаардлагатай. Энэ ажиллагаа л зардал ихтэй. \Л/5В® цэвэрлэгээний технологийн ачаар лагийг зайлуулахад бусад ийм төрлийн байгууламжтай харьцуулахад зардлыг 75% хүртэл хэмнэх боломжтой. Германы Барилгын техникийн хүрээлэнгийн баталснаар бараг лаг хуримтлагддаггүй учраас маш хялбар байгууламж юм.





Цэвэрлэгээний чадлыг дурьдвал.

АНХДАГЧ ТУНГААГУУР 1. Бохир ус байшингаас гарч байгууламж руу орно. Түүхий бодисууд мөн лаг доош сууна. Тэдгээр нь эндээ хадгалагдана. Механикаар цэвэрлэгдсэн ус биологийн цэвэрлэгээний шат руу шилжинэ.

БИОЛОГИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ 2. Дотор хэсэгт микро биетүүд амьдрах тээвэрлэгч материалууд байна. Тэдгээрийн тусламжтайгаар хорт бодисыг 99% хүртэл устгах чадалтай өндөр түвшний Биофилмийг үүсгэнэ.

АГААРЖУУЛАЛТ 3. Биологийн цэвэрлэгээний шат нь микро биетүүд хорт бодисыг устгахад шаардагдах агаараар буюу хүчил төрөгчөөр хангагдана.

ХОЁРДОГЧ ТУНГААГУУР 4. Биологийн цэвэрлэгээнээс гарсан хатуу бодисууд шаланд тунаж үлдэнэ.

ЛАГ ЦЭВЭРЛЭХ 5. Хоёрдогч тунгаагуураас лагийн үлдэгдлийг зайлуулна.

ГАРАЛТ 6. Цэвэрлэгдсэн ус дээж авах хэсгээр дамжин гол горхи руу урсах ба эсвэл газрын хөрсөнд шингэнэ.

ДЭЭЖ АВАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛСЭН 7. Усны чөлөөт урсгалаас дээжийг авна. Гарч байгаа уснаас шаардлагатай үзүүлэлтүүдийг шинжилэхэд дээжийг энгийн аргаар авахад хангалттай.

MSB® ХЯНАХ M2M 8. MSB® хянах M2M дэвшилтэт удирдлага нь ажлын цаг, нөхцөл байдлын мэдээллийг хадгалж, байгууламжийн ажиллагааг явуулна.

MSB® цэвэрлэгээний цэвэрлэх процесс.

Ахуйн бохир ус лаг хадгалах саваар дамжин анхдагч тунгаагуурын нарийн цэвэрлэгээ рүү орно. Тунгаагдаж болохуйц бодисууд лаг хадгалагч болон анхдагч тунгаагуурт тунгаагдана. Механикаар цэвэрлэгдсэн бохир ус биологийн цэвэрлэгээ рүү шилжинэ. Бүрэн биологийн цэвэрлэгээний зарчим нь Биофилм зарчимд суурилсан: Микро биетүүд бохир усан дахь органик биетийг авч, экологийн бодисын солилцооны бүтээгдэхүүнд хувирахын тулд хуванцар материалууд дээр суурьшина. Энэ тээвэрлэгч материалууд полиэтиленээр хийгдсэн ба 350 -500 м²/м³ хүртэлх хэмжээтэй. Цэвэрлэгээг хийхэд тэдэнд хүчилтөрөгч хэрэгтэй. Компрессороор агаарыг үлээх ба маш нарийн ширхэгтэй агааржуулагчаар усанд агаарыг тараана. Илүүдэл өөрөөр хэлбэл үхмэл микро биетүүд энэ процессын үед ялгарах ба лаг хэлбэрээр хоёрдогч тунгаагуурт цугларна. Хоёрдогч тунгаагуур бол ажиллагааны сүүлчийн хэсэг бөгөөд түүний шаланд тунаж цугларсан лагийг шумбагч мотороор эсвэл өөр системээр зайлуулна. Хоёрдогч тунгаагуураас биологийн аргаар цэвэрлэгдсэн бохир ус гарах хоолойгоор дамжин гадагш урсана.

Бага энерги зарцуулах тохирсон ажиллагаа.

MSB® цэвэрлэгээ процесс нь цахилгаанаар тэжээгдэх удирдлагын хянах хэсэгтэйгээс гадна компрессорууд, хоёрдогч тунгаагуур дахь шумбагч моторыг автоматаар удирдана. Ингэж бага энергээр ажиллагааг явуулахын тулд компрессорууд завсарлагатай ажиллана, өөрөөр хэлбэл солилцох ажиллагаа буюу завсарлах цагтайгаар ажиллана. Ажиллагааны оновчтой үзүүлэлтийг бохир

усны хэмжээнээс хамааран өдрийн явц дунд дахин тохируулах боломжтой. Шумбагч моторын ажлын цагийг биологийн цэвэрлэгээний тасалгаанаас гарах лагийг бүрэн соруулахаар тохируулна. Нитритжүүлэлтээс хамааран хоёрдогч тунгаагуурт түр зуурын хөвөгч лагууд гарч ирэх тал бий. Лаг үүсэх нөхцлийг бий болгохгүйн тулд MSB® цэвэрлэгээ процесс нь хөвөгч лагийн сорогчоор тоноглогдсон. Дагалдах лаг хадгалагчийн хуримтлуулах чадал нь ойролцоогоор 3-4 сар байх ба нийт үүсч бий болох лагийн хэмжээ ойролцоогоор 0,96 л/ОС*д. Лаг хуримтлагдах хугацаа нь цэвэрлэх технологийн чадлыг үзүүлэлтээс хамаарах ба байгууламжийн ажиллагааны явцад тогтоогдоно.

Цэвэрлэх арга бүр чанартай форм.

Гаралтын үзүүлэлтийн шаардлагаас хамааран MSB® цэвэрлэгээ процесс нь стандартчиллагдсан бүтээгдэхүүн биш бөгөөд харин салангид тайлбарлагдах арга юм. Энэ аргын нээлтийн үед Бергманн Группын инженерүүд түүний төлөвлөгөөг дэмжсэн. Мэдээж инженерүүд байгууламжийн төлөвлөгөөний үед түүнийг бүрэн ашиглаж болно. Төгсгөлд нь тэд тэдний төслийн ажилд тогтвортой, суурьтай нээлтийн үзүүлэлтүүд болж чадсан. MSB® цэвэрлэгээний цэвэрлэх процесс биофилм технологид доорх боломжууд бий:

- 500 хүртэлх оршин суугч (ОС)-тай үйлчилгээний газар эсвэл нийтийн барилгад зориулсан цэвэрлэх хэлбэр
- өргөтгөх боломжит модултай бохир усны цэвэрлэгээний хэлбэр
- Жижиг байгууллагад тохирсон цэвэрлэх хэлбэр
- 5000 хүртэлх оршин суугч (ОС)-д зориулсан нийтийн цэвэрлэгээний технологи
- 5000 хүртэлх оршин суугч (ОС)-д зориулсан орчин үеийн цэвэрлэх байгууламж

Нарийвчилсан ажиллагааны давуу талууд:

Дусах биетүүд, шумбагч биетүүд эсвэл байнгын шумбах тавцантай Биофилм зарчимтай харьцуулахад MSB® цэвэрлэгээ процесс нь бага зузаантай давхаргатай, өндөр эсийн нягтралтай Биофилм юм. Түүний онцгой чанарууд нь дараах зарчмын давуу талуудын суурь юм:

- + 12°C-ээс доош температурт нитритжүүлнэ
- + Загварчилсан нитритжүүлэлт ба доод тал нь 30-50% хүртэлх нитритгүйжүүлэлт
- + Хоёрдогч лагийн уналт бага буюу лагийн үйлдвэрлэл бага
- + Өвчин үүсгэгчийн микробиологийн устгал
- + Хордуулагч бодисууд дахь микро биетүүдийн идээшил
- + Ачаалал ихтэй үед ажиллагаанд ямар нэгэн асуудал гарахгүй
- + Хөвөгч хавтгай дээр хүчилтөрөгчийг бүрэн ашиглана



НЭГ АЙЛЫН БАЙШИН ЭСВЭЛ ХЭСЭГ БҮЛГҮҮДЭД ЗОРИУЛАГДСАН ЖИЖИГ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖУУД.

MSB® цэвэрлэгэг та одоогийн байгаа байгууламжид үргэлжлүүлэн ашиглах боломжтой. Зарчмын хувьд бүх байгууламжууд- савны хэмжээг үл хамаарна:

- Сав, оролт гаралтын хоолойнууд чанарын шаардлагыгхангахуйц өндөр түвшинд хийгдсэн байх хэрэпэй.
- Тасалгаа бүрийн эзлэхүүн ба усны түвшин шаардлагын дагуу байх.

Бетон - хамгийн найдвартай арга.

- + Өртөг бага, байгальтай ойр бодис
- + Жижиг байгууламжийн орших хугацаа (байх хугацаа 50 - 80 жил)
- + Байршил-хэлбэр батбөх
- + Барилгын өөрчлөлт хийх боломжтой
- + Тээвэрлэх боломжтой, найдвартай
- + Бетоныг үргэлж байгальд боловсруулдаг



Цэвэрлэгдсэн бохир усны дараагийн зам.

Цэвэрлэгдсэн бохир ус байгууламжаас гарахаас өмнө дээж авах цэг нь сүүлчийн хэсэг болно. Өгөгдсөн хүчин зүйлсээс үл хамааран цааш гарна. Хэрэв бохир ус сувагт ороход тэд шууд бус хоолойны үүрэг гүйцэтгэнэ. Энэ боломжийг ашиглахын тулд та шугам хоолой эзэмшигчтэй зөвшилцсөн байххэрэгтэй. Энэ нь ихэвчлэн холбоо эсвэл бохир ус татан зайлуулах байгууллагууд байдаг. Тухайн хариуцах байгууллагууд шугам хоолойнд тавигдах шаардлагыг тодорхойлж өгдөг. Ингэснээр ямар шаардлагыгхэрхэн хангасны дараатаны бохирусугхоолой руу орох боломжтой болох нь тодорхой болно.

Бохир ус эргээд байгалийн эргэлтийн нэгэн хэсэг болно.

Эдгээрийг цэвэрлэгдсэн бохир ус хоолойн оронд шууд урсаж байгаа эсвэл тогтмол голд цутгахад шууд хоолой гэж нэрлэнэ. Ер нь бол цэвэрлэгдсэн бохир усыг таны амьдарч байгаа газарт шууд шингээж болно. Устай холбоотой дүрэм журмын дагуу шийдэгдэнэ. Бусад мэдээллийг та өөрийн усны байгууллага болон биднээс асууж тодруулах боломжтой.

MSB® цэвэрлэгээний чанарт цэвэрлэгдсэн бохир усны гаралт хамаарагдана. Энэ даалгаврыг биелүүлэхэд танд олон боломж бий. Бохир усны цэвэрлэгээний чанарын тал дээр дээж авч шинжилнэ. Үүний тулд жижиг цэвэрлэх байгууламжид дээж авах нөхцлийг бүрдүүлж өгсөн байх хэрэгтэй. Ингэхийн тулд байгууламжийн хоёрдогч тунгаагуурт дээж авах хэсгийг хийнэ. Хоёр дахь боломж бол дээж авах хугдгийг тусад нь хийх.

WSB® ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ОЛОН УЛСАД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСӨН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ХҮЧИН ЧАДАЛ.

Итгэх баталгаа бол олон улсын шалгалтууд...

№5B® цэвэрлэгээ нь 2005 оноос хойш улс орон бүрийн шаардлагад нийцэж хүлээн зөвшөөрөгдөх олон шалгалтыг даван туулсан. АНУ болон Канад улсуудын шаардлагууд их өндөр байсан, яагаад гэвэл цэвэрлэгээний технологийн үзүүлэлт Герман улсаас 4 дахин их байсан. Мөн Дани, Европын улсууд, Сауди-Араб улсуудад \Л/5ВФ цэвэрлэгээг амжилттай нэвтрүүлсэн. Дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн найдвартай, удаан хугацааны цэвэрлэгээ хийх чадалтай технологийг танд санал болгож байна.

Ачаалал бага түвшинд чадвартай...

Хамгийн жижиг цэвэрлэх байгууламж нь 4 хүнд зориулагдаж стандартчилгдсан байдаг. Онцгой тохиолдолд л цөөн хүмүүст зориулж хийх боломжтой. Мөн олон гэр бүл амьдардаг байшин, цайны газар, амралтын газар зэргүүдэд мөн хамаарна. Албан газрууд харин ачааллыг тохируулах талаар ярьдаг. \Л/5В® клэн ачааллын бага түвшинд ажиллах чадвартай ба 1 хүнд зориулсан байгууламжаас эхлээд өндөр түвшний цэвэрлэгээг санал болгож байна. Зөвхөн энэ ч биш: зогсолтын үеийн дараа, жишээлбэл таныг аялалаас буцаж ирэхэд \Л/5В® клэн шууд ажиллах чадвартай.

1929 оноос эхлэн цэвэр инженерийн урлаг...

Дэлхий даяар хялбар шийдлүүд хамгийн их нөлөөтэй байдаг. Хүрээлэн буй орчинд ээлтэй технологийг Берглданн Групп усны элеллентийн амьдарлын баталгаа болгож байна. Өсөж буй хувийн, нийтийн, үйлдвэрийн хэрэглээнээс болж энэ нь өөрийн мөн чанарыг алдаж байна. Шахалт, бохирдуулалт нь ус түгэх үйлдлийг зогсоож байгаа нь хүн төрөлхтний нэгэн тулгамдсан асуудлуудын нэг болж байна.

Үүний тулд 1929 оноос эхлэн Захсэн мужийн Кэмицийн ойролцоох Пениг хотын Бергманн групп Эргэх-Хөвөгч биет-Биофилм (\Л/5В®) зарчмыг нээж олсон. Энэ зарчмын цэвэрлэгээний чадал, энгийн, найдвартай байдал нь (\Л/5В®) клэний олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн явдал юм. Ингээд гэр бүлийн компани маань энэ хугацаанд европ тивийн төвлөрсөн бус цэвэрлэх технологийн хамгийн амжилттай компани болж, мөн ололт амжилтын зам болж чадсан: хүн бүрт зориулсан удаан хугацааны цэвэр ус.

-> Бидэнтэй холбоо барьж бүрэн биологийн технологийн цэвэрлэгээний чадлыг мэдрэхийг хүсье.

Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоотой хамтран ажиллагч ХБНГерман улсын БЕРГМАНН Групп






ХУВИЙН ОРОН СУУЦНЫ ХАЛААЛТ, УС ХАНГАМЖ, БОХИР УСЫГ ШИЙДЭХ АРГА ЗАМУУДААС

Хувийн орон сууц гэхээр заавал байшин гэж ойлгоод гэр хамаагүй юм шиг ойлгодог явдал бий. Орчин үед гэрийг ч орчин үеийн инженерийн тоноглолоор тоноглож тохь тухтай амьдрах боломж бүрдсэн. Тиймээс гэртээ ч ,байшиндаа ч дараах санаануудыг авч ашиглахад болох учиртайг эхлээд хэлье. Хамгийн түрүүнд халаалтын талаар авч үзье. Халаалт гэдэг нь хүний тав тухтай байх температурыг орон байрандаа бий болгохын нэр . Яагаад тохьгүй нөхцөл үүсдэг гэхээр орон байранд хүйтэн болсноос үүддэг. Яагаад хүйтэн байна гэхээр дулааны алдагдал байгаа учраас хүйтэн байгаа юм. Гэр байшин хаагуураа их дулаан алддаг гэхээр хана, тааз,дээврээр хамгийн их дулаан алддаг. Дулаан агаар хөнгөн байдаг учир дээшээ хөөрч алддаг бол хүйтэн агаар хүнд учир доогуур нэвтэрч орж ирдэг юм. Манайхан доогуур сэнгэнээд байна гэлцдэг нь тийм учиртай . Мэдээж хаалга,цонх,тооноор бол их дулаан алдах магадлал бий. Тооцоогоор бол нийт дулаан алдагдлаас ханаар 25%,таазаар 20%,шал руу 15%,цонхоор 15% гэхчлэн алддаг байна.



Тэгэхээр хаагуур их дулаан алдаж байна тэр хийцийн дулаан тусгаарлалтыг сайн хийх нь ач холбогдолтой болно. Барилгын материал бүр харилцан адилгүй дулаан дамжуулдаг. Сийрэг хөнгөн бүтэцтэй материал дулаан бага нэвтрүүлдэг буюу дулаан сайн хадгалдаг. Гадна агаарын хэм -40оС байх үед 2,13 м бетон хана тусгаарлах дулааныг 34 см зузаан мод,12 см зузаан шилэн хөвөн, 7,5 см хөөсөнцөр орлодог байна.



Иймд ямар материал сонгож байшингаа барих нь хамгийн эхний чухал шийдэл болно. Байшингаа барьлаа гэхэд ашиглалтын зардал гэж юмыг тооцоолсон байх ёстой.Сайн дулаалгатай байшин бариад ашиглалтын явцад түлшний зардлаа хэмнэх үү,хямдхан, дулаалга муутай байшин бариад хожим нь их түлш хэрэглэж зардал гаргах уу гэдгээ бодож үзэх ёстой. Байшин бол олон жил ашиглах учиртай хөрөнгө. Иймд ашиглалтын зардлаа сайн тооцох нь түлш үнэтэй үед анхаарахгүй өнгөрч болохгүй зүйл юм.Байшингаа дулаалах үед анхаарах юмны нэг нь гаднаас нь дулаалах уу,дотоос